

ADB

Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

Төслийн дугаар: 54209-001

Техникийн туслалцаа

ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД МОНГОЛ УЛСАД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ШИЙДВЭРЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Энэхүү зөвлөх үйлчилгээний тайлан нь АХБ, Засгийн газрын санаа бодлыг илэрхийлэхгүй бөгөөд АХБ болон Засгийн газар энэхүү тайлангийн агуулгын төлөө хариуцлага хүлээхгүй болно.

2022 оны 12-р сар

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
АХХХ	Ариутгал халдвартгүүлэлтийн хамгаалах хэрэгсэл
ТХБ	Түр хамгаалах байр
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЖСХ	Жендерт сууринсан хүчирхийлэл
ХБ	Хамтарсан баг
МООНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ТББ	Төрийн бус байгууллага

Гарчиг

ХУРААНГУЙ	4
I. ТАНИЛЦУУЛГА	8
A. ОРШИЛ	8
B. МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ	10
C. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	12
D. АХБ-НЫ ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА	12
II. ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ	14
A. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	14
B. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	14
C. Тайланг эцэслэх явц	16
III. ТӨСЛИЙН ГОЛ ҮР НӨЛӨӨ	16
B. ҮР ДҮН 2: ГБХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ОНЛАЙН ЗӨВЛӨГӨӨ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ	19
IV. АНХААРАХ ГОЛ АСУУДЛУУД	38
A. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ	38
B. ГБХ-ИЙН ХОХИРОГЧИДТОЙ АЖИЛЛАДАГ НЦҮТ, ТХБ, ЦАГДААГИЙН АЖИЛТНУУД БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ	39
C. ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, АНХАН ШАТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ДУТМАГ	40
V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД	40
A. ДҮГНЭЛТҮҮД	40
B. СУРГАМЖ, САЙН ТУРШЛАГА	43
C. ЗӨВЛӨМЖҮҮД	45
Хавсралтууд	48
Хавсралт 1. Мэдээлэл цуглуулсан аргууд	48
Хавсралт 2. НЦҮТ ба Түр хамгаалах байруудын мэдээлэл	49
Хавсралт 3. Нөлөөллийн үнэлгээний байршил ба бусад төслүүдийн байршил	51
Хавсралт 4. Мэдээлэл цуглуулсан судалгааны хэрэглэгдэхүүн	53
Бүлгийн ярилцлага хийх заавар:	53
Түр Хамгаалах Байр, Нэг Цэгийн Үйлчилгээний Төв, Цагдаагийн Хэсгийн Анхан Шатны Тусламж Үзүүлэгчидтэй хийх ярилцлага	53
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн анхан шатны үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудтай хийх ярилцлагын заавар	55
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнтэй хийх ярилцлагын заавар	57
Хакатонд шалгарсан багуудтай хийх ярилцлагын заавар	59
НЦҮТ/ХБ-ны үр шим хүртэгчидтэй, ГБХ-даван туулагч эмэгтэйчүүдтэй хийх ярилцлагын заавар	61

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь” Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан	
Олон нийтийн төлөөлөлтэй фокус бүлгийн хэлэлцүүлэг	63
Хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, цагдаагийн хэсгийн анхан шатны тусlamж үзүүлэгчдээс авах судалгааны заавар	65

ХУРААНГУЙ

КОВИД-19 цар тахал болон түүнээс үүдэлтэй хорио цээрийн дэглэмийн улмаас эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, нийгэм-эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлсэн. Цар тахал нь эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдал, эрүүл мэндийн тогтолцооны чадавх зэрэг хүчин зүйлээс хамааран улс орнуудад өөр өөр нөлөөллийг үзүүлсэн.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлсэн хорио цээрийн арга хэмжээ нь гэр бүлийн орчинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг нэмэгдэхэд нөлөөлжээ. Тухайлбал, 2020 оны эхний улиралд Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил 61.6 хувиар өссөн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн 93 хувь нь эмэгтэйчүүд байдаг¹. Мөн цагдаагийн шуурхай дуудлагын утсанд ирсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага мэдээлэл 19%-иар, төрийн бус байгууллагын тусламжийн утасны дуудлага 30%-иар нэмэгдсэн байна.² 2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах хүмүүсийн тоо 50 хувиар нэмэгджээ.³

Монгол улсад “Ковид-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь” МОН-6530 техникийн туслалцаа (ТТ)-ны төсөл нь Ковид-19 цар тахлын жендэрийн ялгаатай нөлөөллийг бууруулах, ялангуяа эмэгтэйчүүдэд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байсан. ТТ-ны хүрээнд дараах үр дүнг зорьсон:

Үр дүн 1. Гэр бүлийн хүчирхийлийн эсрэг хариу арга хэмжээг дэмжиж, хамгаалах байруудын хүчин чадлыг бэхжүүлэх;

Үр дүн 2: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, онлайн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох;

Үр дүн 3: Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх;

ТТ нь КОВИД-19 тахлын улмаас үүссэн хямралын үед авч хэрэгжүүлсэн хөл хорионы нөхцөлд яаралтай тусламж үзүүлэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх зэрэг онцгой байдлын үеийн тусламж, үйлчилгээг хохирогчдод хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой байв. ТТ нь КОВИД-19-ийн онцгой байдлын үед яаралтай арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэх шаардлагатай дараах гурван асуудлыг тодорхойлон, түүнд анхаарал хандуулж ажилласан. Үүнд:

- i. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэгдсэн тохиолдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ;
- ii. Анхан шатны хариу арга хэмжээ авах, хамгаалах байрны үйлчилгээнд аюулгүй байдлын протокол, тоног төхөөрөмж дутмаг байгаа;
- iii. Яаралтай тусламжийн утасны үйлчилгээний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд хариу өгөх чадвар хангалтгүй байсан зэрэг болно.

Үр нөлөөний үнэлгээ. Төслийн үр нөлөөний үнэлгээ нь (i) хямралын үед гэр бүлийн хүчирхийлийн эсрэг хариу арга хэмжээ авах механизм; (ii) урьдчилан сэргийлэх арга

¹ Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэргийн статистик мэдээ. 2020 оны эхний 3 сар.

² НХХЯ. 2020. Түргэвчилсэн үнэлгээний тайлан. М.Чанцалдулам, Б. Цогбаяр нар НУБХАС/ШХА-ын төслийн хүрээнд бэлтгэв.

³ НХХЯ. 2020. Түргэвчилсэн үнэлгээний тайлан. М.Чанцалдулам, Б. Цогбаяр нар НУБХАС/ШХА-ын төслийн хүрээнд бэлтгэв

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

хэмжээг сайжруулсан байдлыг үнэлсэн. Үр нөлөөний үнэлгээ нь ТТ-ны хүрээнд онцгой байдлын үед авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний сургамж, үр нөлөөг судалж тус улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цаашдын үйл ажиллагаанд ашиглах сургамжийг тодорхойлох зорилгыг агуулсан.

Үнэлгээний үр дүн.

Үр дүн 1. Төслийн Үр дүн 1-ийн хүрээнд анхан шатны тусlamж үзүүлэгчид, хамгаалах байрны ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах ариутгал халдвартгуйжүүлэлтийн хэрэгсэлүүд, болон шүүх эмнэлгийн тусlamж үйлчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор зөөврийн хэт авиаан оношлогооны аппарат худалдан авч өгөхөөр төлөвлөжээ.

Үр нөлөөний үнэлгээгээр Үр дүн 1-ийн хүрээнд төлөвлөсөн худалдан авалтын ажлууд цаг үеэ опсныг харуулж байна. Анхан шатны тусlamж үзүүлэгчид болон хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгааллын хувцас, нэг удаагийн маск, бээлий, халдвартгуйжүүлэх хэрэгсэл, гар ариутгагч, саван, зайнлас халуун хэмжигч термометр зэрэг цар тахлын үеийн ариутгал, халдвартгуйжүүлэлтийн хамгаалах хэрэгсэл (АХХХ)-ийг худалдан авч, улсын хэмжээний 14 түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээний төв, нийслэлийн Цагдаагийн хэлтэст хүлээлгэн өгчээ. Энэхүү хангамж нь аймгуудын НЦҮТ/ТХБ-д Ковид-19 тохиолдол гарахаас өмнө очсон анхны бөгөөд хамгийн чухал хангамж байсан. Хохирогчдын шүүх шинжилгээнд ашиглах зориулталт бүхий 3 ширхэг зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (ШШҮХ)-д хүлээлгэн өгсөний нэг нь Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны лабораторид хуваарилагджээ.

АХХХ-ээр хангагдсан нь үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний үйлчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндэд ээрэгээр нөлөөлсөн. НЦҮТ/ТХБ-ны нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын үеэр нийгмийн ажилтнууд маск, нүүрний халхавчтай ажиллах нь тэдэнд дэмжлэг болж, үйлчлүүлэгч хүлээж авахдаа аюулгүй, тайван байдлыг мэдрүүлж байсныг хэлж байлаа. Үр нөлөөний үнэлгээний судалгаагаар хувийн хамгааллын хэрэгсэлд хамгийн хэрэгцээтэй зүйлс нь маск, гар ариутгагч, гарын саван байсан гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Судалгаанд оролцогчид эдгээр зүйлсийг олон удаа болон удаан хугацаанд ашиглах боломжтой байсныг хэлж байв.

ТТ-ны дэмжлэгтэй зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг хүлээн авсны дараа ШШҮХ нь өөрийн байрандаа оношилгоо шинжилгээ хийхээс гадна хорих анги гэх мэт өөр байршилд очиж оношилгоо шинжилгээ хийх боломжтой болжээ. ШШҮХ-ийн эмч нар уг аппаратын чанарт сэтгэл хангалийн байсан. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн их эмч 2022 оны жилийн эцэс гэхэд гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор 138 шинжилгээ хийсний 58 нь буюу 42 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч байжээ.

Үр дүн 2. ТТ-ийн Үр дүн-2-ын хүрээнд КОВИД-19 цар тахлын үед ГБХ-ийн хохирогчдод шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, ГБХ-ийн мэдээлэгдсэн тохиолдлын тоог нэмэгдүүлэхэд чиглэж байсан.

КОВИД-19 цар тахлын үед ГБХ-н чиглэлээрх чатботуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх олон сувагт мэдээлэл сурталчилгааны кампанит ажил маш хоцорч эхэлсэн. Каманит ажлын үйл ажиллагаанууд 2022 оны 8-р сарын сүүлээр буюу чатботуудыг ажиллуулж эхэлснээс хойш нэг жил гарангын дараа эхэлсэн. МҮОНРТ нь телевиз, урт долгиоогоо хэвлэл мэдээллийн кампанит ажлыг нэвтрүүлэх гол сувгаар

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

сонгосон. Гэвч боловсруулсан телевиз, радиогийн сурталчилгаа, нэвтрүүлгүүд нь чатботуудын талаар мэдээлэл өгөх тал дээр үр дүн муутай байсан. Учир нь ФБЯ-д оролцсон ихэнх хүмүүс нэвтрүүлгүүдийг үзээгүй ба/эсвэл агуулгыг нь ойлгоогүй байсан. Чатботын шинэ хэрэглэгчдийн дийлэнх нь уг үйлчилгээний талаар МҮОНРТ-ын Facebook зэрэг олон нийтийн сүлжээнээс мэдсэн гэжээ. Гэвч чатботуудын гол зорилго нь цар тахлын үед ГБХ-ийн хохирогчид болон тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх зорилготой байсан ч чатботын шинэ хэрэглэгчид чатботуудын талаар КОВИД 19-ийн хязгаарлалт зогсоны дараа мэдсэн байна.

ХЗДХЯ-ны дэргэдэх үндэсний Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн (ХЗҮХ) болон Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” (ХЭҮТ) төрийн бус байгууллага нь чатбот болон цахим зөвлөгөө өгөх үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор ширээний компьютер хүлээн авсан. 2021 оны 4-р сараас ХЗҮХ болон ХЭҮТ хоёр тус бүр чатбот үйлчилгээг ажиллуулж эхэлсэн. Хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд хүрэхийн тулд чатботуудод мессеж бичих функцийг оруулж өгсөн. ТТ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх яаралтай тусламжийн утсыг 7 хоногийн 24 цагийн турш тасралтгүй ажиллуулах зорилгоор ХЭҮТ-д нэг яаралтай утасны зөвлөгч нэмэлтээр, ХЗҮХ-д хоёр оператор ажиллуулахад дэмжлэг үзүүлсэн.

ХЭҮТ-ийн мэдээлснээр чатбот ажиллаж эхэлснээс хойшх эхний гурван сарын хугацаанд 158 шинэ хэрэглэгч чатботтой холбогдсон бол 2022 оны 12 сарын байдлаар 1109 шинэ хэрэглэгч холбогдож мэдээлэл авсан байна. ХЗҮХ-ийн чатбот нь 2022 оны 12-р сарын байдлаар 7410 харилцан яриа хэрэглэгчээс хүлээн авсны ихэнх нь сэтгэл зүйн зөвлөгөө авахаар холбогдсон (32.6%) байна. ХЭҮТ-ийн чатбот үйлчилгээ нь хүчирхийлэлд өртсөн хохирогчид НЦҮТ болон хамгаалах байрны үйлчилгээ аваагүй тохиолдолд сэтгэл зүйн дэмжлэг авч болох боломжтой цорын ганц үйлчилгээ юм.

ХЗҮХ нь зөвхөн хууль зүйн зөвлөгөө өгдөг тул ХЗҮХ-ийн чатбот нь хүчирхийллийн төрөл хэлбэр, гэр бүл цуцлалтын талаарх мэдээлэл өгдөг. 2022 оны 5-р сараас 9-р сарын хооронд 246 иргэн хууль зүйн зөвлөгөө авчээ.

Хакатоныг Монгол Масс Медиа (МММ) ХХК, "Старт-Ап" ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тэмцээнд оролцохоор 72 баг бүртгүүлж, тэдгээрийн 16 нь хагас шигшээд сонгогдсон. Эцсийн шатанд хоёр баг шилдгээр тодорсон байна. Хоёрдугаар шатанд шалгарсан хоёр загвар нь: (а) "Тарзов" багийн боловсруулсан вэбд суурилсан цахим дээрэлхэлтийг бүртгэх мэдээллийн сантай, тухайлбал Цагдаагийн байгууллагатай бүрэн холбох боломжтой, мөн үнэл төлбөргүйгээр өөрийн үнэлгээ хийх функцтэй "Онлайн SOS" бэлгийн дарамтын талаар мэдээлэх платформ, (б) Монголын нөхцөлд зориулан #MeToo брэндийг хөгжүүлж, тоглоомын загвар ашиглан эрсдэлийн үнэлгээний онлайн хэрэглүүрийг бүтээсэн "#MeToo" баг байсан.

Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээр хоёр удаагийн сургалтыг НЦҮТ болон ТХБ-ны ажилтнуудад зохион байгуулсан бөгөөд үүнд улсын хэмжээнд НЦҮТ/ТХБ-ны 175 ажилтан хамрагдсан. Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээрх 3 өдрийн тусгайлсан сургалтыг зохион байгуулж, улсын хэмжээнд цагдаагийн 60 сэтгэл зүйч хамрагджээ.

НЦҮТ/ТХБ-ны судалгаанд хамрагдагсан ажилтнууд бүгд энэхүү сургалтыг хэрэгтэй гэж үзсэн ба 92.3 хувь нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үзсэн. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь сургалтыг цаг үеэ олсон (96.2%) гэжээ. Түүнчлэн сургалтад оролцсон НЦҮТ/ТХБ-ын ажилтнууд сургалт нь өөрийн сэтгэцийн эрүүл мэндээ нэн тэргүүнд тавих ёстойг ойлгуулсан гэж хариулсан. Судалгаанд оролцогчдын 88.5% нь сургалтын зохион байгуулалтыг сайн гэж үзсэн ч цахим сургалтын хэлбэрийг оролцогчдын 60% нь л үр дүнтэй гэжээ. Учир нь сургалт ажлын цагаар зохион

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

байгуулагдсан учраас сургалтад хамрагдагчдын ихэнх нь ажилтай холбоотой бусад
үүргээ гүйцэтгээд сургалтад анхаарлаа бүрэн төвлөрүүлж чадаагүй гэжээ.

Үүний нэгэн адил цагдаагийн сэтгэл зүйчдийн тал хувь нь өмнө нь ижил төстэй сургалтад
хамрагдаж байсан ч 93% нь тус сургалтыг хэрэгтэй байсан гэж үзсэн байна. Судалгаанд
оролцогчдын 80 орчим хувь нь сургалт нь тэдний ажлын гүйцэтгэлд тодорхой
хэмжээгээр нөлөөлсөн гэдэгтэй санал нийлж, 93 хувь нь сургалтыг сайтар төлөвлөсөн
гэж үзсэн байна. Цагдаагийн сэтгэл зүйчийн үүрэг бол цагдаагийн алба хаагчийн
сэтгэцийн эрүүл мэндэд тусламж үзүүлэхээр бэлтгэгдсэн хэдий ч тэд захиргааны бусад
ажил үүргийг голчлон гүйцэтгэдэг байна. Ажил үүргийн ийм хуваарилалт нь сэтгэл зүйч
мэргэжлийнхээ хүрээнд цагдаагийн алба хаагчдад цаг алдалгүй сэтгэл зүйн дэмжлэг
үзүүлэхэд саад болдог байна. Харин сургалтын үр дүнд энэ үндсэн чиг үүрэгтээ илүү
анхаарал хандуулах болжээ.

I. ТАНИЛЦУУЛГА

A. ОРШИЛ

1. Коронавируст халдвар (КОВИД-19) нь дэлхийн эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг өдөөж, үүний улмаас дэлхийн хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлсэн. Цар тахал нь улс орон бүрт эрүүл мэндийн тогтолцооны уян хатан байдлаас хамааран өөр өөр байдлаар нөлөөлсөн. Мөн КОВИД-19 нь бага, дунд орлоготой ихэнх орнуудын⁴ эрүүл мэндийн тогтолцооны чадавх хангалтгүйн улмаас эрүүл мэндийн яаралтай тусlamжийн бэлэн байдал дутмаг байгааг харуулсан. Үүнтэй адилаар КОВИД-19 нь Монгол улсын эрүүл мэндийн салбарын эмзэг байдлыг харуулсан⁵.
2. Монгол Улс КОВИД-19 цар тахлын эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, цаашдын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн анхны улс орнуудын нэг болохын хувьд хилээ хааж, олон нийтийн үйл ажиллагааг хязгаарлаж, сургууль, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг⁶ түр зогсоосон. Монгол Улсын Засгийн газраас цар тахалаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих зорилгоор үе шаттайгаар өөрийгөө тусгаарлах хорио цээрийн дэглэм тогтоох бодлого баримталсан⁷. КОВИД-19 цар тахал дэгдэлтийн үеэр тавьсан хязгаарлалтын зарим нь олон нийтийн арга хэмжээг цуцлах, хөл хорио тогтоох, олон нийтийн арга хэмжээ, чухал бус жижиглэнгийн үйлчилгээнд хязгаарлалт хийх зэрэг байсан.
3. КОВИД-19 цар тахал нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт ч олон талаар нөлөөлсөн. 2020 оны эхээр тус улсын эдийн засгийн өсөлт 10.7%-иар буурсан нь ДНБ-ий 24%-ийг бүрдүүлдэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 30%-иар буурсантай холбоотой. ДНБ-д⁸ үйлчилгээний салбар (39%) хамгийн их хувь, тэр дундаа худалдаа эзэлдэг бөгөөд цар тахлын тархалтыг хянахтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас 6.8%-иар буурсан байна⁹. Хямрал нь тус улсын хүн амыг хамарч эрэгтэй, эмэгтэй хүмүүс үр нөлөөг өөр өөрөөр мэдэрчээ. Монгол Улсад эрэгтэйчүүд халдвар авах эрсдэл өндөртэй, эрүүл мэндийн үр дагаварт өртөх нь илүү байсан¹⁰. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд (i) эрүүл мэндийн салбарт гүйцэтгэдэг үүрэг илүү¹¹, (ii) цар тахалтай холбоотой

⁴ А.Дагвадорж, Б.Жанцансэнгээ. 2022. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эсрэг эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ: Монгол улсын сургамж. The Lancet Regional Health - Western Pacific 2022. [https://www.thelancet.com/pdfs/journals/lanwpc/PIIS2666-6065\(22\)00051-7.pdf](https://www.thelancet.com/pdfs/journals/lanwpc/PIIS2666-6065(22)00051-7.pdf) хаягаар авах боломжтой.

⁵ --

⁶ Гомбодорж, Г., Пето, К. 2022. Монгол Улсын ямар төрлийн өрхүүд COVID-д хамгийн их өртөж байна ву? Sustainability 2022, 14, 3557. <https://doi.org/10.3390/su14063557>

⁷ --

⁸ --

⁹ --

¹⁰ Н. Чен нар. 2020. БНХАУ-ын Ухань хотод шинэ төрлийн коронавирусын уушгины хатгалгааны 2019 оны 99 тохиолдлын тархвар, эмнэлзүйн шинж чанарын тайлбар судалгаа. Lancet.

¹¹ Монгол улсын эрүүл мэндийн салбарын ажиллах хүчиний 82 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг (АХБ, 2020. Техникийн тусlamжийн тайлан. Монгол улс: КОВИД-19 цар тахлын хямралын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх нь.)

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

хязгаарлалтын улмаас гэр бүлийн жижиг бизнесийн цар хүрээ, ашиг орлого нь
багассан зэрэг бэрхшээлтэй нүүр тулж байв¹².

4. КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд хөл хорионы дэглэм тогтоож, хүмүүсийг гэртээ байхыг шаардаж байсан улс орууладад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдсэн байна. Түүнчлэн Монгол Улсад цар тахлын үед эдийн засгийн хүндэрэл, амьдралын нөхцөл байдлын улмаас гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдэх болсон. 2020 оны эхний улиралд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 3,100 болж өмнөх оны мөн үеээс 63%-иар нэмэгдсэн нь цагдаагийн байгууллагад бүртгэгджээ¹³. Нийт тохиолдлын 77% нь бие маходийн хүчирхийлэл, 90% нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн 93 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүний зэрэгцээ цагдаагийн шуурхай утсанд гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага, мэдээлэл 19%-иар, төрийн бус байгууллагын тусlamжийн утасны дуудлага 30%-иар нэмэгдсэн гэж мэдээлсэн байна¹⁴. 2020 оны эхний сууруудад гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, хамгаалах байраар үйлчлүүлэх шаардлагатай үйлчлүүлэгдийн тоо 50 хувиар нэмэгджээ¹⁵.
5. Монгол Улс 2020 оны эхээр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэнд, хууль эрх зүй, зөвлөгөө өгөх, богино хугацаанд байршуулах үйлчилгээ үзүүлдэг 14 түр хамгаалах байр, 15 НЦҮТ (нэг цэгийн үйлчилгээний төв)-тэй байсан. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх зорилгоор КОВИД-19 цар тахлын үеэр бүх түр хамгаалах байр, НЦҮТ-үүд нээлттэй хэвээр байсан. Гэхдээ эдгээр байгууллагуудад хохирогчдод аюулгүй тусlamж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ариутгал халдвартгүйжүүлэлтийн хамгаалалтын хэрэгсэл (AXXX) дутмаг байв. Түүнчлэн хамгаалах байрууд болон НЦҮТ-д ирсэн шинэ хохирогчдыг хүлээн авч, байрлуулах үед үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчдийг КОВИД-19-д өртөх эрсдэлийг бууруулах протокол байхгүй байв. Үүнээс гадна байгууллагууд ариутгал, халдвартгүйжүүлэлтийн материал худалдаж авах төсөв хомсдолтой байжээ. Үүний улмаас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид, тэдэнд анхан шатны үйлчилгээ үзүүлэгчид, тухайлбал хамгаалах байр, НЦҮТ-ын ажилтнууд, цагдаагийн ажилтнууд халдварт авах эрсдэл өндөртэй байсан.
6. Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдэхийн хэрээр уг эрэлт хэрэгцээнд хариу өгөх сувгууд болох 24 цагаар ажиллах цагдаагийн шуурхай дуудлагын утас (107), ХЭҮТ төрийн бус байгууллагын гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх 09:00-18:00 цаг хүртэл ажилладаг зөвлөгөө өгөх утаснуудын хүчин чадал хязгаарлагдсан хэвээр байсан. Энэ нь хөл хорио тогтоосон хорио цээрийн үед хохирогчдын үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж байсан.

¹² АХБ, 2020. Техникийн тусlamжийн тайлан. Монгол улс: КОВИД-19 цар тахлын хямралын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх нь.

¹³ НХХЯ. 2020. Түргэвчилсэн үнэлгээний тайлан. М.Чанцалдулам, Б. Цогбаяр нар НУБХАС/ШХА-ын төслийн хүрээнд бэлтгэв.

¹⁴ --“--

¹⁵ --“--

В. МОНГОЛ УЛС ДАХ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

7. Монгол улсад ЖСХ-ийн тархалт өндөр байна. Монгол Улсад 2017 онд хийсэн Жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний судалгаагаар 15-аас дээш насны охид, эмэгтэйчүүдийн 12.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд одоогийн болон өмнөх дотнын хамтрагчийнхаа үйлдсэн бие махбодийн, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байсан болохыг харуулжээ¹⁶. Мөн судалгаагаар 15-аас дээш насны эмэгтэйчүүд, охидын 2.6 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ойр дотны хүнээсээ өөр хүний бэлгийн хүчирхийлэлд өртсөн болохыг тогтоожээ¹⁷. ҮСХ-ны 2017 оны судалгаагаар хамтран амьдрагчтай байсан эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь амьдралынхаа туршид бие махбодийн болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан нь дэлхийн дундаж тооцоолол болох 30 хувьтай ойролцоо байна¹⁸.
8. Судалгаанаас хараад амьдралынхаа туршид сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн (40.3%), хяналтандaa байлгах зан үйлд (41.6%) өртсөн хувь өндөр байсан өгөөд одоогийн харилцаандаа 22.4% ба 23.8% нь дээрх хүчирхийлэлт өртдөг байна. Хяналтандaa байлгах зан үйлийн тархалтыг насны бүлгээр авч үзвэл амьдралынхаа туршид хяналтандaa байлгах зан үйлийн хүчирхийлэлд өртсөн дундаж хувь 41.6% -тай байхад 15-19 насны өсвөр насны охидын дунд одоогийн эсвэл өмнөх хамтрагчийнхаа хяналтанд байдаг хувь 54.7% байсан байна¹⁹. Дотны хамтрагчтай байсан эмэгтэйчүүдийн таван хүн тутмын нэг нь (19.9%) амьдралдаа, харин 12 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна. Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (57.9%) амьдралынхаа туршид таван төрлийн хүчирхийллийн аль нэг буюу хэд хэдэн төрлийн хүчирхийлэлд өртөж байсан бол гуравны нэг буюу 35 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлсэн (Зураг 1-ийг харна уу). Тус тайландаа дурьдсанаар залуу эмэгтэйчүүд хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байгаа бөгөөд 2017 онд тэдний 42 хувь нь бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгааг мэдээлсэн байна²⁰.

¹⁶ ҮСХ ба НҮБХАС. 2018. Хүчирхийллийн нүцгэн үнэн: жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан – 2017.


¹⁷ __“__

¹⁸ ҮСХ ба НҮБХАС. 2018. Хүчирхийллийн нүцгэн үнэн: жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан – 2017.

¹⁹ __“__

²⁰ __“__

Зураг 1. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, төрлөөр



Эх сурвалж: УСГ ба НҮБХАС, 2018

9. Уг судалгаа нь ГБХ²¹-ийн мэдээлэх зан үйлд дүн шинжилгээ хийжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 26.5% нь санал асуулга явуулахаас өмнө өөрт тохиолдсон зүйлээ мэдээлээгүй, хэнтэй ч хуваалцаагүй байна. Зөвхөн 8.3% нь хүчирхийллийн талаар мэдээлсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээрийн 23.9% нь хүчирхийлэлд өртөж цагдаад хандсан, 13.2% нь эрүүл мэндийн байгууллагаас тусlamж хүссэн бол 12.5% нь лам ба/эсвэл шашны хүмүүсээс дэмжлэг хүссэн байна. Хамгаалах байр эсвэл бусад хамгаалах үйлчилгээ авах талаар тусlamж хүссэн эмэгтэйчүүдийн хувь 1.5% -иас бага байна.
10. 2017 оны судалгаанд хамрагдсан хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тусlamж хүсээгүй шалтгаан нь хүчирхийллийг улам дэврээхээс айсан (68.6%), ноцтой гэмтэл авсаны улмаас тусlamж авч чадаагүй (42.7%)²² гэжээ. Сүүлийн үеийн судалгаагаар хохирогчид түр хамгаалах байр (ТХБ) болон нэг цэгийн үйлчилгээний төв (НҮЦТ)-тэй холбогдохгүй байгаа шалтгаан нь ийм үйлчилгээ байгаа эсэх талаар хүмүүсийн мэдлэг, ойлголт дутмаг байгаатай холбоотой (судалгаанд хамрагдагчдын 59.6% нь НҮЦТ, ТХБ-ны талаар мэдэхгүй байсан) гэж үзжээ²³. Хүчирхийллийг тэвчих нь гэр бүлээ бүрэн бүтэн авч үлдэж, хүүхдүүдийг өнчрүүлэхээс сэргийлнэ гэсэн итгэл үнэмшил нь хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэхгүй байхад нөлөөлж байж болох юм. 2020 оны судалгаагаар асуулгад хамрагдсан хүмүүсийн 26.3% нь хүчирхийллийг тэвчих нь гэр бүлээ авч үлдэхэд чухал гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна²⁴.

²¹ --“--.

²² --“--.

²³ УСХ ба НҮБ-ын Хүн амын сан. 2020. Жендерт сууринсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлага ба Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байрны үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан. Улаанбаатар.

²⁴ --“--.

С. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

11. Монгол Улсад 2020 оны эхний улиралд ГБХ гэмт хэрэг буурч, 279 гэмт хэрэг бүртгэгдсэн ч КОВИД-19 цар тахлын үед ЖСХ-тэй холбоотой зөрчлийн тохиолдол эрс нэмэгдсэн байна²⁵. Гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой хэргийн 91.8 хувийг эрэгтэйчүүд үйлдсэн бол 41.9 хувийг согтуугаар үйлдсэн байна. Энэ төрлийн хэрэг хот (Улаанбаатарт 48.1%) болон хөдөө орон нутагт (51.9%) өсчээ²⁶. Нийт 273 хүн хүчирхийлэлд өртсөний 238 (87.2%) нь эмэгтэй, 30 (11.0%) нь хүүхэд байна²⁷. Гэр бүлийн хүчирхийлэл өмнөх оны мөн үеийнхээс 18.7%-иар, хүүхдийн эсрэг хүчирхийлэл 2.1%-иар, эмэгтэйчүүдийн хүчирхийлэл 11.7%-иар өссөн байна²⁸.
12. 2020 оны 1-р улиралд НЦҮТ болон ТХБ-ны үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оныхоос 88.7%-иар өссөн байна²⁹. Цагдаагийн шуурхай дуудлагын утсанд ирсэн дуудлага 2019 оны мөн үетэй харьцуулахад 40.8 хувиар өссөн байна³⁰. 2020 оны 1-р улиралд хамгаалах байрны хэрэгцээ өмнөх онтой харьцуулахад 50 хувиар өсчээ³¹.
13. КОВИД-19-ын анхны тохиолдол бүртгэгдсэн 2020 оны 2-р улиралд НЦҮТ болон хамгаалах байранд байгаа хохирогчдын тоо буурсан. Үүний зэрэгцээ шуурхай дуудлагын утсанд хандах, утсаар зөвлөгөө авах, төвүүдээс зөвлөгөө авах нь нэмэгдсэн. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр кибер гэмт хэрэг (2.6 хувиар) бага зэрэг өссөн байна³². Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн хэрэг буурч, харин утсаар ярих, зөвлөгөө авах хүсэлт нэмэгдсэн нь ЖСХ-ийн хохирогчдод хүрэх яаралтай тусламжийн утасны үйлчилгээг сайжруулах, онлайн үйлчилгээг хөгжүүлэх зэрэг алсын зайнаас үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ нэмэгдсэнийг харуулж байсан.

D. АХБ-НЫ ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА

14. КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн туслалцаа (MON-6530) нь Монгол Улсад КОВИД-19-ийн тархалтын жендерийн нөлөөллийг бууруулах, эмэгтэйчүүдэд үзүүлэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг бууруулах арга хэмжээг бэхжүүлэхэд Монгол улсад дэмжлэг үзүүлэх зорилготой. ТТ нь АХБ-ны 2017-2020 онд Монгол Улстай хамтран ажиллах стратегийн зорилтуудтай нийцэж байгаа. ТТ нь АХБ-ны Монгол Улсад КОВИД-19 халдварын тархалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх багцын нэг хэсэг юм.

²⁵ ҮСХ ба НҮБХАС. 2018. Хүчирхийллийн нүцгэн үнэн: жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан – 2017.

²⁶ __“__

²⁷ __“__

²⁸ __“__

²⁹ __“__

³⁰ __“__

³¹ __“__

³² __“__

15. ТТ нь 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр батлагдаж, 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Төсөл 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусна. КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх техникийн туслалцаа нь дараах гурван үр дүнг гаргана.
16. **Үр дүн 1. Гэр бүлийн хүчирхийлийн эсрэг хариу арга хэмжээг дэмжиж, хамгаалах байруудын хүчин чадлыг бэхжүүлэх.** ТТ нь цар тахлын үед анхан шатны тусламж үзүүлж буй ажилагсдын аюулгүй байдлыг хангах зорилгоор (i) Аруитгал халдвартгүйжүүлэлтийн хамгаалах хэрэгсэл (AXXX), анхны тусламжийн багц, халдвартгүйжүүлэлтийн хэрэгслийг улсын хэмжээнд 14 түр хамгаалах байр, 15 НЦҮТ-үүд, цагдаагийн анхан шатны нэгжүүдэд өгөх; (ii) хохирогчдын шүүх шинжилгээнд зориулсж 3 ширхэг зөөврийн хэт авиан аппарат; (iii) дижитал зөвлөгөө өгөх үйл ажиллагааг сайжруулах мэдээллийн технологийн техник хангамж (жишээ нь, ширээний компьютер)-ыг худалдан авч өгөхөд дэмжлэг үзүүлнэ.
17. **Үр дүн 2: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, онлайн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох.** ТТ нь КОВИД-19 цар тахлын үед ГБХ-ийн хохирогчдын хэрэгцээнд нийцүүлэн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ГБХ-ийн талаар мэдээлэх тохиолдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Энэ зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг төлөвлөсөн. Үүнд (i) Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ) болон Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ)-ийн мэдээллийн технологи, дижитал дэд бүтцийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (жишээ нь, чатбот үйлчилгээг бий болгох) замаар одоо байгаа яаралтай утас, зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулах; (ii) КОВИД-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх утга бүхий гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүмүүс, гэр бүлд чиглэсэн мультимедиа олон сувгийн мэдээлэл харилцааны кампанит ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх; (iii) КОВИД-19 цар тахлын үед сэтгэл зүйн зөвлөгөө авах эрэлт хэрэгцээ нэмэгдсэнтэй холбоотойгоор ХЭҮТ-ийн хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ТТ хэрэгжих хугацаанд нэг зөвлөгчийг нэмж санхүүжүүлэх; (iv) кибер орчин дах дээрэлхэлт гэх мэт жендерт суурилсан хүчирхийллийн шинэ хэлбэрийг шийдвэрлэх дижитал шинэлэг шийдлүүдийг тодорхойлох хакатон зохион байгуулах; (v) бэлгийн хүчирхийллийн үед яаралтай тусламж үзүүлэх анхан шатны ажилтанууд болон хамгаалах байрны ажилтнуудад стресс менежмент, сэтгэцийн эрүүл мэндийн талаар онлайн сургалт, цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сургагч багш нарыг бэлтгэх зэрэг сургалтуудыг хийнэ. Үр дүн-2 нь Монгол Улс болон Ази, Номхон далайн орнуудад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цаашдын үйл ажиллагаанд үнэ цэнэтэй сургамж өгнө гэсэн хүлээлттэй байна.
18. **Үр дүн 3: Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх.** КОВИД-19-ын цар тахлын үед хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах чадавх, тэр дундаа мэдээллийн сан, мэдээллийн нууцлалын механизмыг бэхжүүлэх, яаралтай хариу арга хэмжээг хянах чадавхийг сайжруулах чиглэлээр ТТ-ны хүрээнд хэрэгжсэн онцгой байдлын үеийн хариу арга хэмжээнүүдийн үр нөлөө, сургамжийг судалж, тус улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цаашдын үйл ажиллагаанд мэдээлэл өгөх зэрэгт дэмжлэг үзүүлнэ.

II. ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

A. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

19. ТТ нь КОВИД-19 цар тахлын улмаас үүссэн хямралын үед авч хэрэгжүүлсэн хөл хорионы нөхцөлд яаралтай тусlamж үзүүлэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх зэрэг нэн шаардлагатай тусlamж, үйлчилгээг хүчирхийллийн хохирогчдод хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой байв. ТТ нь КОВИД-19-ийн онцгой байдлын үед яаралтай арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэх шаардлагатай дараах гурван асуудлыг тодорхойлон, түүнд анхаарал хандуулж ажилласан.
- i. **Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэгдсэн тохиолдлыг нэмэгдүүлэх шаардлага байсан.** Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол 2020 оны эхний улиралд 63 хувиар өссөн ба тэдгээрийн 77 хувь нь бие маходийн хүчирхийлэл байсан бол 93 орчим хувьд нь эмэгтэйчүүд хохирогч болсон байв. Энэ хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, хамгаалах байрны үйлчилгээ авахыг хүссэн хохирогчдын тоо 50 гаруй хувиар өссөн байна.
 - ii. **Анхан шатны хариу арга хэмжээ авах, хамгаалах байрны үйлчилгээнд аюулгүй байдлын протокол, тоног төхөөрөмж дутмаг байсан.** КОВИД-19 цар тахлын үеэр бүх түр хамгаалах байр, НЦҮТ-үүд нээлттэй хэвийн үйл ажиллагаагаа явуулж байсан. Гэхдээ эдгээр байгууллагуудад шаардлагатай АХХХ байхгүй байсан бөгөөд тухайн үед үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчдийг КОВИД-19 –ын халдвараас хамгаалах протокол байхгүй байв. Үүнээс гадна байгууллагууд ариутгал, халдвартгүйжүүлэлтийн материал худалдаж авах төсөв дутмаг байжээ. Үүний улмаас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид, тэдэнд анхан шатны үйлчилгээ үзүүлэгчид, тухайлбал хамгаалах байр, НЦҮТ-ын ажилтнууд, цагдаагийн ажилтнууд өртөж, халдвэр авах эрсдэл өндөртэй байсан.
 - iii. **Шуурхай дуудлагын утасны үйлчилгээний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд хариу өгөх чадвар хангалтгүй.** Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдэхийн хэрээр уг эрэлт хэрэгцээнд хариу өгөх сувгууд хязгаарлагдмал болсон. КОВИД-19 цар тахлын үед зөвхөн хоёр яаралтай тусlamжийн утас ажиллаж байсанв Үүнд: 24/7 цагийн цагдаагийн яаралтай дуудлагын утас (107), төрийн бус байгууллагын гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх утас 09:00-18:00 цаг хүртэл ажиллаж байсан.
20. Дээр тодорхойлсон асуудлууд дээр үндэслэн төслийн үр нөлөөний үнэлгээ нь (i) хямралын үе дэх гэр бүлийн хүчирхийллийн хариу арга хэмжээ авах механизмыг; (ii) урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулсан байдлыг үнэлсэн. Үр нөлөөний үнэлгээ нь ТТ-ын хүрээнд онцгой байдлын үед авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний сургамж, үр нөлөөг судалж тус улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цаашдын үйл ажиллагаанд сургамж боловсруулах зорилготой байв.

B. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

21. Тайлангийн 20-р зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд тоон болон чанарын холимог мэдээлэл цуглуулах арга зүйг боловсруулсан (Хавсралт 1). Оролцогч талууд, олон нийтийн төлөөлөл, үр шим хүртэгчидтэй хийсэн зорилтот судалгаа,

ярилцлага, хэлэлцүүлгийг тоон болон чанарын мэдээллийг хамгийн сайн хослуулан хийсэн нь ач холдогдол бүхий дүгнэлт гаргахад үндсэн суурь болсон.

22. Үр нөлөөний үнэлгээний үйл ажиллагаа нь үндсэн зургаан хэсгээс бүрдсэн. Үүнд:
- (i) судалгааны асуулга, фокус бүлгийн ярилцлага, гүнзгийрүүлсэн ярилцлагын удирдамж боловсруулах зэрэг бэлтгэл ажил; (ii) хээрийн судалгааны туршилт хийх, мэдээлэл цуглуулах хэрэгслийг засварлах/эцэслэн боловсруулах; (iii) түүвэр судалгааны асуулгыг боловсруулж, эцэслэх; (iv) улсын хэмжээнд 6 аймаг, хөдөөгийн 6 сум, Улаанбаатар хотын хоёр дүүрэг зэрэг 14 газарт хээрийн судалгаа хийх; (v) транскрипт, дүн шинжилгээ, дүгнэлт хийх; ба (vi) эцсийн тайланг бэлтгэх.

23. Зөвлөхүүд ТХБ, НЦҮТ, цагдаагийн анхан шатны нэгж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (ШШҮХ), Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ), Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ)-ийн төлөөлөлтэй хийх ФБЯ-ын удирдамж, ярилцлагын асуултуудыг КОВИД-19-ийн үед ажиллаж байсан туршлага, ТТ-ны өмнөх нөхцөл болон ТТ-ны тусlamж авсны дараах туршлагыг үнэлэх зорилгоор бэлтгэсэн. Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагын асуултууд нь цар тахлын үеийн үйлчилгээ, яаралтай тусlamжийн утас, тусlamжийн хүртээмж зэрэгт чиглэсэн. Олон нийтийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад хэвлэл мэдээллийн кампанит ажлын үр нөлөөг үнэлэх асуултуудыг оруулсан. Харин үнэлгээний багийн бэлтгэсэн санал асуулгын судалгаа нь хамгаалах байр, НЦҮТ, цагдаагийн сэтгэл зүйчдэд чиглэж байсан бө асуултад тэдний хүлээн авсан АХХХ, түүний ашиг тус, мөн тэдгээр байгууллагаас сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтад оролцогчдын төлөөллөөс авсан сургалттай холбоотой асуултууд багтсан болно (Мэдээлэл цуглуулсан асуулгуудыг Хавсралт 4-ээс харж болно).

24. Үндэсний зөвлөх, судалгааны ажилтны хамт 6 аймгийн төв, хөдөөгийн 6 сум, Улаанбаатар хотын хоёр дүүрэг зэрэг 14 газраас хээрийн судалгааны мэдээлэл цуглуулсан. Доорх Хүснэгт 1-д судалгаанд оролцогчдын тоо, мэдээлэл цуглуулсан аргын талаарх бүрэн мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын тоо, ангилал, мэдээлэл цуглуулсан аргаар

Ангилал	Гүнзгийрүүлсэн ярилцлага	Фокус бүлгийн ярилцлага	Анкетийн Судалгаа	Эрэгтэйчүүдийн тоо	Эмэгтэйчүүдийн тоо
НЦҮТ/ТХБ-ны ажилинууд		5 ФБЯ (20 ажилтантай)	29	3 (10.3%)	26 (89.7%)
Цагдаагийн сэтгэл зүйчид	3		29	5 (17.2%)	24 (82.8%)
Даван туулагчид	5			0	5 (100%)
Олон нийтийн төлөөлөл, байршилаар		42 ФБЯ		61 (27.6%)	160 (72.4%)
Нийт	5	47 (241 оролцогчтой)	58	69 (24.3%)	215 (75.7%)

25. Олон нийтийн ФБЯ-ыг зургаан аймгийн төв, зургаан хөдөөгийн сум, нийслэл Улаанбаатар хотын хоёр дүүрэгт зохион байгууллаа. Нэгж бүрт гурван өөр ФБЯ зохион байгуулсан. Үүнд: (а) 35-аас дээш насны эмэгтэйчүүд; (б) 35 ба түүнээс доош насны эмэгтэйчүүд; (в) холимог насны эрэгтэйчүүд. ФБЯ-д хамрагдсан 221

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

хүний 40.8% нь 35 ба түүнээс дээш насын эмэгтэйчүүд, 32.1% нь 35 ба түүнээс дээш насын эмэгтэйчүүд, үлдсэн 27.0% нь эрэгтэйчүүд байсан. Судалгаанд оролцогчдын 86.2% нь гэрлэлтийн байдлын талаарх мэдээллийг нэргүй бүртгэлийн маягтаар өгсөн бөгөөд тэдгээрийн 76.3% нь гэрлэсэн, 13% нь ганц бие, 7.1% нь гэрлэлтээ цуцлуулсан, 3.6% нь бэлэвсэн гэжээ. Судалгаанд хамрагдагсдын 67 хувь нь ажилтай, 33 хувь нь ажилгүй байна. ФБЯ-ыг Монгол хэл дээр хийж, тайландаа зориулан орчуулав.

C. Тайланг эцэслэх явц

26. Энэхүү тайлан нь баримт бичгийн судалгаа, ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, санал асуулгын үр дүнг үндэслэсэн болно. Үүнд: төслийн хэрэгжилтэнд оролцсон ТББ, компаниуд, төрийн байгууллагын төлөөлөл, олон нийтийн төлөөлөл, үр шим хүртэгчдийн төлөөллийн хариултууд багтсан. Төслийг АХБ болон Монгол Улсын Засгийн газрын холбогдох байгууллагуудтай хуваалцаж, ирсэн саналыг тусгалаа. Тайлангийн эцсийн хувилбарыг ХЗДХЯ-д танилцуулж саналыг нь авсан.
27. Тайлангийн үндсэн дүгнэлтийг 2023 оны 1-р сард АХБ, Монгол Улсын холбогдох төрийн байгууллагууд болон гол оролцогч талуудад цахимаар танилцуулсан. Тайланг эцэслэн боловсруулах явцад бүх санал, хүсэлтийг тусгасан. Гол сургамжууд, сайн туршлага, санал болгож буй арга хэмжээг шийдвэр гаргагчид болон гол оролцогч талуудтай хуваалцана.

III. ТӨСЛИЙН ГОЛ ҮР НӨЛӨӨ

28. Энэхүү хэсэгт үнэлгээнд ашигласан баримт бичгүүдийн судалгаа, ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, санал асуулгын хүрээнд цуглуулсан өгөгдлийг ашиглан Техникийн туслалцаа (ТТ)-ны гол үр нөлөөг танилцуулж байна.

A. ҮР ДҮН 1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ДЭМЖИЖ, ХАМГААЛАХ БАЙРУУДЫН ХҮЧИН ЧАДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

29. ТТ нь КОВИД-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, хамгаалах байрны чадавхийг бэхжүүлэх зорилготой. Үр дүн 1-ийн хүрээнд анхан шатны тусламж үзүүлэгчид, хамгаалах байрны ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, шүүх эмнэлгийн хариу арга хэмжээний чадавхийг сайжруулах, зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор худалдан авалтыг төлөвлөжээ. Худалдан авалтад ариутгал, халдвартайжүүлэлтийн хамгаалах хэрэгсэл (AXXX), зөөврийн хэт авиа оношлогооны аппарат, зайнлас халуун хэмжигч термометр, халдвартайжүүлэлтийн материал, мэдээлэл технологийн техник, тооног төхөөрөмж багтсан. Үр дүн 1-ийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөжээ.
 - i. Анхан шатны тусламж үзүүлэгчид, хамгаалах байрны ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хувийн ариутгал, хамгааллын хэрэгсэл худалдан авах
 - ii. Шүүх эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор зөөврийн хэт авиа оношлогооны аппарат худалдан авах

30. Төслийн үйл ажиллагаа тус бүрийн явц, үр нөлөөний дүн шинжилгээг дараах хэсэгт тайлбарлан оруулав.

Анхан шатны тусlamж үзүүлэгчид, хамгаалах байрны ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах ариутгал, хамгааллын хэрэгслийн худалдан авалт

31. **Явц:** Анхан шатны тусlamж үзүүлэгчид болон хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор маск, бээлий, халдвартгүйжүүлэх хэрэгсэл, (анхны тусlamжийн иж бүрдэл), гар ариутгагч, саван, зайнаас халуун хэмжигч термометр зэрэг цар тахлын үеийн ариутгал, халдвартгүйжүүлэлтийн хамгааллын хэрэгслийг худалдан авч, улсын хэмжээний 14 түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээний төв, нийслэлийн Цагдаагийн албадад хүлээлгэн өгчээ.
32. **Үр нөлөө:** НЦҮТ, ТХБ-д өгсөн АХХХ нь “цаг үеэ” олсон хуваарилалт байсан гэж тэдгээр байгууллагын ажилтнууд үзжээ. Аймгийн түвшинд НЦҮТ, ТХБ-уудын анх удаагаа АХХХ-ийн дэмжлэг авсан тохиолдол байсан ба АХХХ-ийг хүлээн авах үед ихэнх аймагт КОВИД-19 бүртгэгдээгүй байсан. Иймээс зарим НЦҮТ болон ТХБ-үүд үйлчлүүлэгчдээ АХХХ-ийг зөв ашиглахыг зааж онцгой нөхцөл байдалд бэлтгэсэн. “Манай үйлчлүүлэгчид гадуур явах, эрүүл мэндийн төв болон бусад үйлчилгээ рүү явахдаа амны хаалт, нүүрний хаалтыг хэрэглэж байсан. Ялангуяа хүүхдүүд амны хаалт хэрэглэх, цар тахлын үед өөрийгөө хэрхэн хамгаалах талаар суралцахдаа их дуртай байсан” гэжээ. (Дорнод аймгийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан, мониторингийн ярилцлага, 2021 оны 5-р сар)
33. Улсын хэмжээнд 15 НЦҮТ, 14 ТХБ-ын 255 анхан шатны үйлчилгээ үзүүлэгчид, АХХХ болон бусад хангамжаас үр шим хүртсэн. Дэмжлэг авсан НЦҮТ/ТХБ нь өдөрт 312 хохирогчийг хүлээн авах хүчин чадалтай. Үр нөлөөний үнэлгээгээр 2021 оны 2, 3-р саруудад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1594 иргэн НҮТЦ/ТХБ-аар үйлчлүүлсэн; тэдгээрийн 761 нь хүүхэд, 98 нь насанд хүрэгчид (96% эмэгтэйчүүд) байсан. Энэ хугацаанд нийт 422 хүүхэд (үүнээс 60% нь охид) шинээр ирж, 357 насанд хүрэгчид (85% эмэгтэй), 709 хүүхэд (55% охид) биечлэн зөвлөгөө авчээ.
34. Нийслэлийн цагдаагийн нийтийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан хаагчдад АХХХ тараажээ. Нийслэлийн цагдаагийн газрын нийт 1398 алба хаагчдад АХХХ-ийг хүлээлгэж өгчээ.
35. АХХХ-ээр хангагдсан нь үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний үйлчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлсөн. НЦҮТ/ТХБ-ийн нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас хараад нийгмийн ажилтнууд масктай ажиллах нь тэдэнд дэмжлэг үзүүлж байгаа мэдрэмжийг төрүүлж байсан гэжээ. Түүнчлэн ажилтнууд үйлчлүүлэгчдийг хүлээж аваходаа аюулгүй, тайван байдлыг мэдэрч байснаа хэлж байлаа. Улаанбаатар хотын нэгэн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан хэлэхдээ: “Хохирогчид энд ирэхдээ ихэвчлэн гэрээсээ яaran зугтаж ирдэг тул илүү хувцас, ариун цэврийн хэрэгсэлгүй байдаг. Иймээс тэд хувийн хамгааллын хэрэгслийг баяртайгаар хүлээн авдаг. Ялангуяа хүүхдүүд нүүрний хаалт, маск авсандаа үнэхээр баяртай байсан”. (Нийгмийн ажилтан, НЦҮТ, Улаанбаатар, мониторингийн ярилцлага, 2021 оны 5-р сар)
36. НЦҮТ-ийн болон түр хамгаалах байрны ажилтнуудын дунд хийсэн үр нөлөөний үнэлгээний судалгаагаар хувийн хамгааллын хэрэгсэлд хамгийн хэрэгцээтэй

зүйлс нь маск, гар ариутгагч, гарын саван байсан гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Судалгаанд оролцогчид эдгээр зүйлсийг дахин болон байнга ашиглах боломжтой байсныг хэлж байв. Бүх байгууллагууд үйлчлүүлэгчдийн температурыг зайнаас тогтмол хэмжих шаардлагатай байсан тул зайнаас халуун хэмжигч термометр ч бас хэрэгтэй зүйлүүдийн нэг байсан. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн хамгаалах байруудад “КОВИД-19” халдвартын дэгдэлт гарсны дараа зайнаас халуун хэмжигч термометр олдохгүй байсан нь уг термометрийн эрэлт хэрэгцээ ихэсч, орон нутгийн зах зээлээс олдохгүй байсантай холбоотой байжээ. Тиймээс АХХХ иж бүрдэл дотроос хамгийн хэрэгтэй зүйл бол халуун хэмжигч термометр гэдэгтэй хамгаалах байрны ажилтнууд санал нэгджээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар: “Үйлчлүүлэгчдтэй харилцахдаа АХХХ ашиглах нь эерэг сэтгэгдэл, аюулгүй, цэвэр орчинд байгаа мэдрэмжийг төрүүлж байсан”. “Хохирогчид, эмэгтэйчүүд, хуухдууд болон манай ажилтнууд эдгээр зүйлсийг өдөр бүр хэрэглэж байсан нь эерэг мэдрэмжийг бий болгож байсан” (НЦҮТ, ТХБ-ны ажилтнуудын анкетийн судалгаанаас).

37. АХХХ-ийн иж бүрдэл дотор парацетамолыг их хэмжээгээр өгсөн тул хамгийн бага ашиг тустай зүйл гэж тодорхойлсон. АХХХ-ийн түгээлт хийснээс хойш нэг жилийн дараа зарим НЦҮТ/ТХБ-үүд парацетамолыг хадгалсаар байгаа бол бусад НЦҮТ/ТХБ шаардлагатай хүмүүст эмийг өгч, эсвэл хэрэгтэй эм, витаминаар сольж хэрэглэж байна.

Шүүх эмнэлгийн тусlamж үйлчилгээний чадавхийг сайжруулахад зориулах зөөврийн хэт авиа оношлогооны аппаратны худалдан авалт

38. **Явц.** Хохирогчдын шүүх шинжилгээнд зориулж З ширхэг зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүлээлгэн өгсөний нэг нь Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний лабораторид хуваарилагджээ.
39. **Үр нөлөө.** ТТ-ны дэмжлэг үзүүлэхээс өмнө ШШҮХ цорын ганц, суурин, хуучирсан хэт авиа оношлогооны аппараттай байсан. Тус хүрээлэн хохирогчдыг дижитал оношилгоонд оруулахын тулд өөр өмнэлэг рүү явуулах шаардлагатай байсан. ТТ-ны дэмжлэгтэй зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг хүлээн авсны дараа ШШҮХ нь өөрийн төхөөрөмжөөр оношилгоо хийхээс гадна хорих анги гэх мэт өөр байгууллага дээр очиж оношилгоо хийх боломжтой болжээ. ШШҮХ-ийн эмч нар уг төхөөрөмжийг чанартай төхөөрөмж байсан гэж үзэж байсан.
40. Хөвсгөл аймаг нь 148 мянган хүн амтай, гэмт хэргийн гаралт өндөртэй (улсдаа 2-р байранд) томоохон аймгийн нэг тул аймгийн Шүүхийн шинжилгээний лабораторид нэг хэт авиа оношлогооны аппаратыг өгсөн. Хэт авиа оношлогооны шинэ аппаратыг хүлээн авснаас хойш нэг сарын хугацаанд 94 хүн шинэ хэт авиа оношлогооны аппаратаар оношлогдсоны 48 нь танхайн гэмт хэргийн (31), хүчингийн гэмт хэрэг (3), гэр бүлийн хүчирхийлэл (15), зам тээврийн осол (3 хэрэг), бусад гэмт хэргийн (7 хэрэг) улмаас шүүх эмнэлгийн үйлчилгээ авсан байна.
41. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шинжилгээний лабораторийн их эмч 2021 оны жилийн эцэс гэхэд гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор 515 удаагийн хэт авиан оношилгоо хийсэн байна. Тэдгээрийн 38 тохиолдол нь 0-17 насны хүүхэд, 477 нь 18-аас дээш насны насанд хүрэгчид байна. 515 хүний 65 буюу 12.6 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн байна. Шүүхийн шинжилгээний лабораторийн Хөвсгөл аймаг дахь салбар 2022 оны 12-р сар гэхэд гэмтэж бэртсэн 640 хүнд хэт

авиан оношилгоо хийснээс 0-17 наасны 38, 18-аас дээш наасны 477 иргэн байна. Оношилгоонд хамрагдсан 640 хүний 78 буюу 12.1 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байна. Түүгээр ч зогсохгүй хэт авиа оношлогооны аппаратыг хүлээн авснаар илүү ашиг тустай тохиолдлууд бий болж байна. Жишээлбэл, ГБХ-д өртсөн хохирогчийг ГБХ-тэй холбон оношилж байх явцад тухайн хохирогч хорт хавдрын эрт үедээ байгааг оношилсон тохиолдол гарсан.

42. Улаанбаатар хот дах ШШҮХ-ийн эмч нар 2021 онд бэлгийн хүчирхийллийн 32, гэмт хэргийн хохирогч болсон 15 тохиолдлыг хэт авиа оношлогоонд хамруулсан бол 2022 оны есдүгээр сарын байдлаар бэлгийн хүчирхийллийн 39, гэмтлийн 18 тохиолдлыг оношилгоонд хамруулжээ.

В. ҮР ДҮН 2: ГБХ-ЭС СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ОНЛАЙН ЗӨВЛӨГӨӨ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ

43. Үр дүн 2-ын хүрээнд ТТ нь КОВИД-19 хямралын үед ГБХ-ийн хохирогчдын хэрэгцээг хангах зорилгоор мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ГБХ-эс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэгийг сайжруулах, мэдээлэгдсэн ГБХ-ийн тохиолдлын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Үр дүн 2-ын хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөжээ.

- i. Зорилтот хүн амд чиглэсэн мультимедиа сувгийн мэдээлэл харилцааны кампанит ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх
- ii. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод нийгмийн дэмжлэг болон хууль эрх зүйн мэдээлэл өгөх, бусад үйлчилгээнд холбон зуучлах зорилго бүхий чатбот болон гар утасны мессежний функцийг бүтээж, тохируулах;
- iii. Кибер орчин дах дээрэлхэлт гэх мэт хүчирхийллийн шинэ хэлбэрийг шийдвэрлэх дижитал шийдлүүдэд зориулсан хакатон зохион байгуулах;
- iv. ГБХ-ийн үед анхан шатны тусlamж үзүүлэгчдэд зориулсан онлайн сургалтыг зохион байгуулах;

44. Төслийн үйл ажиллагаа тус бүрийн явц, үр нөлөөг шинжилж, мэдээллийг доорх байдлаар оруулав.

Зорилтот хүн амд чиглэсэн мультимедиа сувгийн мэдээлэл харилцааны кампанит ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх

45. Мультимедиа мэдээлэл харилцааны кампанит ажил нь (i) хорио цээрийн дэглэмийн үеийн хэл хорионы дэглэмтэй холбоотойгоор эрсдэлд өртөх явдал нэмэгдэх, хохирогчид болон гэр бүлийн бусад гишүүдийн мэдээлэл, тусlamж авахад тулгарч буй хүндрэлийг бууруулах; мөн (ii) цахим орчинд илүү их цаг зарцуулдаг өсвөр насынхны дунд бэлгийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор ЖСХ-ын эсрэг дижитал платформыг сурталчлах, таниулах зорилготой. Мэдээлэл харилцааны кампанит ажил нь цахим платформ руу урсгалыг чиглүүлж, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүмүүсийг чатботууд, гар утасны програмууд, хувийн чат бүлгүүд, вэбсайтууд (өөрөөр хэлбэл, ХЭҮТ болон ХЗҮХ-ийн вэбсайтууд), мэдээллийн сошиал хуудас гэх мэт цахим боломжоосоо хамаарсан боломжит сонголтууд руу чиглүүлэх зорилготой байсан.

46. **Явц.** КОВИД-19 тахлын үед ЖСХ-ийн эсрэг чатботуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх мультимедиа сувгийн мэдээлэл сурталчилгааны кампанит ажил

удаашралтай эхэлсэн. Үйл ажиллагаанууд 2022 оны 8-р сарын сүүлчээр буюу чатботуудыг ажиллуулж, КОВИД-19 хязгаарлалтыг цуцалснаас хойш нэг жилийн дараа эхэлсэн. Хугацаа хойшлогдонон улмаас чатботууд 2021 оны 4-р сард ямарч сурталчилгаагүйгээр ажиллаж эхэлсэн. ХЗҮХ нь энэ хугацаанд чатботын мэдээлэл, сурталчилгааны зарыг боловсруулж, цахим хуудас дээрээ сурталчилж байсан. Телевиз, радиогийн тэргүүлэгч суваг болох Олон нийтийн МҮОНРТ-ийг тус мэдээлэл сурталчилгааны кампанит ажлыг хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулжээ. Үг кампанит ажил 2022 оны 9-р сард эхэлсэн. МҮОНРТ өөрийн үндэсний телевизийг хэвлэл мэдээллийн кампанит ажлыг нэвтрүүлэх гол сувгаар сонгосон³³. Телевиз үзэлтийн судалгаагаар 42 ба түүнээс дээш насын хүмүүсийн 81-82%, 26-40 насын хүмүүсийн 73% нь ажлын өдрүүдэд 14-21 цагийн хооронд зурагт үздэг байна³⁴. Үүний нэгэн адил 42 ба түүнээс дээш насын хүмүүсийн 76%, 26-40 насын хүмүүсийн 68% нь амралтын өдрүүдэд зурагт үзэж цагийг өнгөрөөдөг. Түүнчлэн өвлүүн улиралд 11-р сараас 4-р сар хүртэл зурагт үзэх цаг нэмэгддэг³⁵. МҮОНРТ кампанит ажлын богино хэмжээний видео контентыг өдөр бүр оройн 20:00 цагаас эхэлдэг мэдээний оргил цагаар түгээж байсан. МҮОНРТ-ээс “Телевиз үзэлт”-ийн судалгаанд үндэслэн сурталчилгааны агуулгыг дамжуулахад тохиromжтой цаг, нэвтрүүлгийг сонгосон байна.

47. МҮОНРТ-ээс ирүүлсэн төслийн саналд хэвлэл мэдээллийн кампанит ажилдаа ажиллах уран бүтээлийн мэргэжлийн боловсон хүчнийг тэдний ажлын даалгавартай нийцүүлэн санал болгосон байна. МҮОНРТ-ээс санал болгосон мэргэжилтэнүүдэд МҮОНРТ-ийн радиогийн хүүхэд, залуучуудын нэвтрүүлгийн ерөнхий редактор, найруулагчийг оруулаагүй байсан. Төслийн дотоод удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хуваарьт өөрчлөлт орсны улмаас санал болгосон мэргэжлийн баг төсөлд оролцож чадаагүй. Үүний улмаас төслийг хэрэгжүүлсэн уран бүтээлийн багийн гишүүд ТТ-ын зорилго, хүлээлтийн талаарх ойлголт, мэдээлэл муутай байсан.
48. Мэдээлэл сурталчилгааны кампанит ажлын даалгаврын тодорхой бус байдал нь ерөнхий зорилго, зорилтыг буруугаар ойлгох, зохион байгуулалтгүй багц үйл ажиллагаа болоход хүргэсэн. Жишээлбэл, КОВИД 19-ийн үед ГБХ-ийн хохирогчдод дэмжлэг үзүүлэхийн тулд шинээр боловсруулсан чатботуудыг сурталчлах нь хэвлэл мэдээллийн кампанит ажлын гол зорилго байсан юм. Түүнчлэн кампанит ажлын амжилтыг баталгаажуулах гол үйл ажиллагааны нэг болох хэвлэл мэдээллийн кампанит ажлын нэвтрүүлэг, мессежийг урьдчилан турших ажлыг хэрэгжүүлэгүй байна.
49. МҮОНРТ-ээс гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн эерэг харилцааг сурталчлах зорилгоор 10 богино хэмжээний видео, “Нээлттэй цонх” телевизийн хөтөлбөр, өглөөний нэвтрүүлэг бэлтгэжээ. “Нээлттэй цонх” нэвтрүүлэг нь амьдрал дээр тохиолдсон бодит тохиолдолын талаар ярилцдаг ток шоу, хосуудын харилцааны талаар ярилцдаг энтертайнмент хэсгүүдийг хослуулсан нэвтрүүлэг юм. МҮОНРТ телевизээс гадна МҮОНРТ-ийн урт долгионы радиог хөдөө орон нутаг руу чиглэсэн хэвлэл мэдээллийн сурталчилгааны сувгаар сонгожээ.

³³ Монгол Улсад хийсэн 2020 оны судалгаагаар нийт 1.9 сая хүн телевиз үздэг бөгөөд үүнээс аймаг, хөдөөгийн хүн амын 94%, Улаанбаатар хотын иргэдийн 90%; Гэр хорооллын иргэдийн 94%, орон сууцны оршин суугчдын 90%, эрэгтэйчүүдийн 935, эмэгтэйчүүдийн 92% нь тогтол телевиз үздэг.

³⁴ Максима. 2020. Телевиз үзэлтийн судалгаа.

³⁵ --“--.

50. МҮОНРТ нь олон нийтийн сүлжээ болох фэйсбүүкийг телевиз, радио нэвтрүүлгийг сурталчлах зорилгоор ашигласан. Нийт 34 фэйсбүүк мэдээг бэлдэж фэйсбүүкээр түгээсэн.
51. **Үр нөлөө.** Фокус бүлгийн ярилцлагаас дүгнэхэд КОВИД-19 цар тахлын үед ГБХ-ээс урьдчилан сэргийлэх мессежийг түгээх хамгийн сайн суваг бол телевиз гэдэг нь харагдаж байсан. Телевиз үзэлтийн судалгаанаас үзэхэд ТВ үзэлтийн хамгийн оргил цаг бол оройн мэдээний үе³⁶ гэжээ. Харамсалтай нь Ковидын дараах үед цөөн хүн телевизийн мэдээ үзэж байгаа бөгөөд ихэнх нь телевизийн сурталчилгааг огт үздэггүй гэжээ. ФБЯ-аас харахад оройн цагаар 45-50 наснаас дээш насныхан, тэр дундаа өндөр настай эрэгтэйчүүд л телевизийн мэдээ үздэг гэжээ. Тэд сурталчилгааны шторкуудыг гаргадаг оройн 20:00 цагийн МҮОНРТ-ийн мэдээ, 18:00 цагаас ТВ-9 телевизийн “Монгол коммент” нэвтрүүлэг, 19:00-20:00 цагийн бусад мэдээг үздэг. Гэсэн хэдий ч өнөө үед телевизийн олон суваг байдаг тул хүмүүс сурталчилгаа үзэхгүй байна. Доорх ишлэлүүд нь ФБЯ-д оролцогчдын үзэл бодлыг харуулж байна. “Хөдөө орон нутгийнхан сурталчилгаа үздэггүй. Би хувьдаа жишээ нь зөвхөн мэдээ үздэг болохоос сурталчилгаа үзэхгүй” (Аймаг-2, эрэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар). “Би хааяа л зурагт үздэг. Үзэхдээ дуртай киногоо л үздэг. Дараа нь 18.00 цагаас “Монгол коммент”, 20.00 цагаас МҮОНРТ-ийн мэдээ”-г хүлээн авч үздэг (Аймаг-3, 35-аас дээш насны эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар).
52. Үнэлгээний баг хэвлэл мэдээллийн кампанит ажилд зориулж боловсруулсан ТВ сурталчилгааг ФБЯ-д оролцогчдод үзүүлэхэд хэн ч зурагтаар уг сурталчилгааг үзсэнээ санаагүй. Үүнээс гадна, ФБЯ-д оролцогчдын дийлэнх нь гол санааг ойлгоогүй, зарим нь гол санааг бүр буруу ойлгосон байв. Сурталчилгаануудын нэгнийх нь эхлэлийн хэсэг нь хэт урт болсноос үүдэн “шинэ орон сууцны сурталчилгаа” байна гэж буруу ойлгосон байв.
53. ГБХ-ийн хохирогчдод зөвлөгөө өгөх, бусад үйлчилгээнд холбон зуучлах үүрэгтэй сумдын хамтарсан багийн гишүүд чатботуудын талаарх телевизийн сурталчилгааг үзээгүй гэж байв. “Багийн Засаг даргын хувьд хамтарсан баг, хүүхдийн эрхийн талаар хангалттай мэдээлэл, мэдлэгтэй. Харин чатбот үйлчилгээний талаарх сурталчилгааг огт хараагүй юм байна” (Сум-1, эрэгтэйчүүдийн ФБЯ, 2022 оны 10-р сар).
54. ФБЯ-д оролцогчид дараах шалтгааны улмаас мэдээллийн кампанит ажлын сурталчилгааг үзэж чатботын талаар ойлгоогүй, учир нь: (а) сурталчилгаа нь чатботын талаар мэдээлэл өгөөгүй, (б) сурталчилгаанд ашигласан уг хэллэгийг ойлгоход хэцүү, (в) сурталчилгаа нь үзэгчдийн анхаарал татахуйц сонирхолтой байгаагүй. Дээрх шалтгаануудыг батлах ФБЯ-ын зарим хэсгийг ишлэл болговол: “Чатбот нь гадаад уг учраас олон хүмүүс чатбот гээж юу болохыг ойлгодоггүй” (ХЭҮТ-ийн ТХБ-ны менежертэй хийсэн ярилцлага). “Би чатбот гээж юу болохыг ойлгосонгүй. Гэхдээ энэ бол фэйсбүүк мессеж гэдгийг танаас сая л мэдлээ” (Аймаг 1.4, эрэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 11-р сар). “Би сурталчилгааг үзсэн ч анхаарал хандуулаагүй. Та бүхэн бидэнд дахин үзүүлэхэд сурталчилгааг үзэж байснаа санав. Гэхдээ би зорилгыг нь ойлгосонгүй” (Аймаг 1.3, эрэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар) “Сурталчилгаанаас харахад цагдаагийн утсанд хандаарай гэсэн. Гэхдээ бид Улаанбаатар хот дах энэ утсанд орон нутгаас холбогдож болдогыг мэдээгүй байсан” (Хөдөөгийн сум,

³⁶ Максима. 2020. Телевиз үзэлтийн судалгаа.

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан
аймгийн бүх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй хийсэн ФБЯ, 2022 оны 11-р
сар).

55. ФБЯ-ын оролцогчид ГБХ болон хүчирхийллийг зурагтаар хэт дэлгэрэнгүй үзүүлж болохгүй гэсэн санааг хуваалцаж байлаа. ГБХ-ийн хохирогч нэгэн эмэгтэй: “Төлөөвизийн нэвтрүүлгээр гэр бүлийн хүчирхийллийн тухай ярих болгонд нөхөр маань сувгаа сольдог. Харин энэ сурталчилгаа шууд хүчирхийлэл гэж яриагүй учраас би бол үзчих л юм байна” (Аймаг, залуу эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар). Өөр нэг эмэгтэй ярихдаа: “ГБХ-ийн хүчирхийлэлд өртөж, нөхөртөө зодуулснаас хойш нэг жилийн дараа ч хүчирхийллийг харуулсан нэвтрүүлгийг үзэж чаддаггүй байсан. Учир нь тухайн явдал толгойд шууд орж ирж, уйлмаар санааддаг” (Аймаг 1.2 эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар)
56. ЦЕГ-ын 102, 107 дугаарын утас үнэ төлбөргүй, утсандаа нэгжгүй байсан ч холбогдох боломжтой гэдгийг аймаг, хөдөөгийн сумын иргэд, тэр дундаа хамтарсан багийн гишүүд, багийн Засаг дарга нар ч мэдэхгүй байсан. Аймаг, сумдын ФБЯ-д оролцогчид эдгээр утсыг зөвхөн нийслэлд л ашиглах боломжтой гэж боддог. Түүнчлэн, сурталчилгааны өмнөх хувилбаруудад МЕССЕЖ бичиж болох яаралтай тусламжийн утасны дугаарыг оруулаагүй байсан. Тиймээс үнэлгээний багийнхан үнэлгээний урьдчилсан үр дүнг МҮОНРТ-тэй хуваалцсан. МҮОНРТ үнэлгээний багийн саналд үндэслэн 2022 оны 11-р сарын сүүлээс эхлэн ХЭҮТ, ХЗҮХ-ийн чатботуудыг тусгайлан сурталчлах шинэ сурталчилгааг боловсруулсан байна.
57. Радио сонсохын давуу талыг ФБЯ-ийн оролцогчид хэлэхдээ “радиогоо тавьчихаад өөрийн ажил, тэр дундаа гэр орны ажил хийж байхдаа юм сонсох боломжтой” гэжээ (Аймаг-3, 35-аас дээш насны эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 11-р сар). Гэхдээ урт долгионы радио төхөөрөмжийн хүртээмж улс орон даяар хязгаарлагдмал байв. Урт долгионы радиог телевиз, интернетэд холбогдоогүй өндөр настангууд л зөвхөн ашигладаг. Аймгаас судалгаанд оролцогчдын зарим нь автомашин жолоодож байхдаа FM радио сонсдог гэж хариулжээ. Гэвч мультмедиа кампанит ажилд зөвхөн Улаанбаатар хот дах МҮОНР-ын FM радио сувгийг ашигласан.
58. Аймаг, сумын төвөөс судалгаанд оролцогчдын дийлэнх нь фэйсбууук ашигладаг болохыг ФБЯ харуулж байв. Бүх насны эмэгтэйчүүд, залуу эрэгтэйчүүд фейсбуукийг байнга ашигладаг. 35-аас доош насны залуу эмэгтэйчүүд хүүхдүүд нь зурагт үздэг, эсвэл гэрийн ажил хийгээд завгүй байдаг тул зурагт үзэх нь ховор байдаг. ФБЯ-т оролцогч бүх эмэгтэйчүүд, тэр дундаа залуу үеийнхэн фэйсбууукээс нэмэлт мэдээллийг өдрийн турш аль цаг завтай үедээ авах боломжтой гэдгээ илэрхийлсэн байна.
59. ХЭҮТ, ХЗҮХ-ийн чатботууд 2022 оны 10-р сараас эхлэн бүх шинэ хэрэглэгчдээс “Чатботын талаар хаанаас мэдсэн бэ” гэсэн асуултыг асуусан. Хоёр чатбот хэрэглэгчдийн 30 орчим хувь нь чатботуудын талаар МҮОНРТ-ын фейсбууукээс мэдсэн байв. ХЗҮХ-ийн чатбот хэрэглэгчдийн 35% нь чатботын талаар ХЗҮХ-ийн вэбсайт гэх мэт интернет сайтуудаас олж мэдсэн гэжээ. ХЭҮТ-ийн чатботын шинэ хэрэглэгчдийн 25 орчим хувь нь ХЭҮТ-ийн вэбсайт, 15 хувь нь найз нөхөд/хамт ажиллагсад болон бусад хүмүүсээс мэдсэн байна. ХЭҮТ, ХЗҮХ-ийн чатбот хэрэглэгчдийн 14% болон 7% нь чатботын талаар МҮОНРТ-ийн телевиз, радиогоос мэджээ. Хэвлэл мэдээллийн кампанит ажил эхэлснээс хойш ХЭҮТ-ийн чатбот хэрэглэгчдийн тоо аажмаар нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 3. ХЗҮХ-ийн чатбот сувгийн талаар мэдээлэл авсан эх сурвалж

Суваг	Тоо #	%
MNB фейсбууук	37	31%
MNB ТВ, радио	8	7%
ХЗҮХ вэбсайт	9	8%
Интернет	31	26%
Найзууд/хамт олон/бусад	12	10%
Хариулаагүй	22	18%
2022 оны 10-р сараас 12-р сар хүртэлх хэрэглэгчдийн тоо	119	100%

Хүснэгт 4. ХЭҮТ-ийн чатбот сувгийн талаар мэдээлэл авсан эх сурвалж

Суваг	Тоо #	%
MNB фейсбууук	97	30%
MNB ТВ, радио	44	14%
ХЭҮТ вэбсайт	7	2%
Интернет	25	8%
Найзууд/хамт олон	14	4%
Бусад	36	11%
Хариулаагүй	97	30%
2022 оны 10-р сараас 12-р сар хүртэлх хэрэглэгчдийн тоо	320	100%

60. Мэдээлэл сурталчилгааны кампанит ажил эхэлснээс хойш ХЭҮТ-ийн чатбот хэрэглэгчдийн тоо, ялангуяа өсвөр насны хэрэглэгчдийн тоо өссөн гэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг нийгэм, хууль эрх зүйн мэдээллээр хангах, хариу үйлчилгээнд холбон зуучлах чатбот, гар утасны мессежний функцийг боловсруулах


61. ТТ нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ-үеийн технологи ашигласан тусламж үйлчилгээний сувгийг туршихаар төлөвлөж, чатботыг суурилуулсан. Чатбот нь хүний дэмжлэггүйгээр харилцан ажиллахаар програмчлагдсан тул хүний амьд харилцаа шаарддаг яаралтай тусламжийн дуудлагад хариулах операторуудын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байна.

62. **Явц.** ХЗДХЯ-ны дэргэдэх Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн (ХЗҮХ) болон Хүчирхийлийн эсрэг үндэсний төв” (ХЭҮТ) төрийн бус байгууллага нь чатбот болон цахим зөвлөгөө өгөх үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор компьютер хүлээн авсан. 2021 оны 4-р сарын байдлаар ХЗҮХ болон ХЭҮТ-д хоёр чатбот ажиллуулж эхэлсэн.

63. Чатботыг хөгжүүлэхээр үндэсний чатбот хөгжүүлэгч компани “Андууд Лаб” ХХК-ыг гэрээлсэн. “Андууд лаб” ХХК нь ХЗҮХ, ХЭҮТ -ийн ажилтнуудад чатботыг хэрхэн ажиллуулах, танигдаагүй бичвэрүүдийг хэрхэн таниулах талаар улирал тутмын сургалтыг зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Чатботууд контент хөгжүүлэх нарийн үйл явцыг тулсан бөгөөд хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг нарийвчлан тохируулах ажил үргэлжилж байна.

64. ХЭҮТ, ХЗҮХ нь чатботуудын харилцан ярианы функцийг хангах агуулгыг боловсруулж оруулсан. ХЭҮТ, ХЗҮХ нь харилцан ярианы функцийг зориулж олон тооны асуулт хариултыг (Асуулт ба Хариулт) боловсруулсан. ХЭҮТ нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, сэтгэл зүйн эрүүл мэнд, гэр бүлийн харилцааны асуудлаар түгээмэл асуудаг 400 асуулт, хариултыг боловсруулсан. ХЗҮХ нь гэр бүлийн хүчирхийллийн хууль эрх зүйтэй холбоотой түгээмэл асуудаг 270 асуулт, хариултыг боловсруулсан. ХЭҮТ, ХЗҮХ нь мэдээллийг хялбар ойлгуулах үүднээс инфографик хэлбэрээр боловсруулжээ.
47. Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь амьдардаг хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд хүрэхийн тулд чатботуудод мессеж бичих функцийг оруулж өгсөн. Чатботуудад утасны мессежийн функцтэй байх нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй болон интернетэд холбогдох боломжгүй хүмүүст уг үйлчилгээг ашиглах боломж олгодог. ХЭҮТ нь мэдээллийн кампанит ажил эхлэхээс өмнө утасны мессежийг ашиглаж эхэлсэн. Монголд баяр ёсполын үеэр ГБХ-ийн тохиолдол ихэсдэг тул ХЭҮТ олон нийтийн баярын ёсполын үеэр олон нийтэд чиглэсэн мессежийг түгээсэн.
48. YCX-ны 2020 оны хүн амын тооллогын³⁷ дүнгээр Монгол Улсад, тэр дундаа эмэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ өндөр байна. Доорх зургаас харахад бүх насны эмэгтэйчүүд гар утас хэрэглэдэг. Тиймээс чатбот үйлчилгээний талаарх мэдээлэл, мэдлэгийг түгээх зорилгоор гар утасны мессежийг ашиглахыг зөвлөж байна.



Зураг 2. Хүн амын гар утасны хэрэглээ, хувь, нас, хүйсээр

49. ТТ нь гэр бүлийн хүчирхийллийн яаралтай тусlamжийн утсыг 7 хоногийн 24 цагийн турш (ердийн ажиллах цаг 08:00-17:00 цаг байсан) ажиллуулах зорилгоор ХЭҮТ-д нэмэлт нэг зөвлөгч, ХЗҮХ-нд хоёр операторыг ажиллуулахад дэмжлэг үзүүлэв. Үүний үр дүнд ХЭҮТ-ийн зөвлөгчид өдөрт дундажаар 8 хүнд, сард 240 хүнд шууд үйлчилгээ үзүүлжээ. ХЗҮХ зөвлөхүүд 2022 оны 5-р сараас 12-р сар

³⁷ YCX. Хүн ам, орон сууцны тооллого, 2020,

хүртэлх хугацаанд 612 хүний хууль эрх зүйн холбогдолтой асуултад хариу өгсөн
байна.

50. ХЗҮХ-ийн чатбот нь ХЗҮХ-ийн Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн дэргэд ажилладаг. ХЗҮХ чатбот нь хүчирхийллийн талаар мэдээлэх функцтэй, гар утасны мессежийн сувагтай холбогдсон бөгөөд цагдаа болон ХЭҮТ үйлчилгээтэй холбох боломжтой.
51. ТТ-ын хүрээнд чатботуудыг ажиллуулахын өмнө чатботуудын талаар мэдээлэл өгөх, мэдлэгийг бий болгох зорилгоор мультимедиа кампанит ажил төлөвлөсөн. Гэвч мэдээлэл сурталчилгааны аяны хэрэгжилт нэлээд хоцорч эхэлсэн. Хэвлэл мэдээллийн кампанит ажлыг дуусгахын тулд орон даяарх телевизийн суваг, урт долгионы радиогийн сүлжээ бүхий МҮОНРТ-ийг сонгон шалгаруулжээ. Хэвлэл мэдээллийн кампанит ажил 2022 оны 9-р сард эхэлсэн.
52. **Үр нөлөө.** 2020 оны 5-р сард³⁸ хийсэн ХНХЯ-ны түргэвчилсэн үнэлгээнээс харахад НЦҮТ, хамгаалах байранд байрлах үйлчлүүлэгчдийн тоо буурч, яаралтай тусlamжийн утсанд ирсэн дуудлага, зөвлөгөө авахаар ирсэн богино хугацааны айлчлалын тоо нэмэгдсэн байна. Цагдаагийн шуурхай дуудлагын утасны (107) мэдээллээс харахад зөвлөгөө авах дуудлага 2020 оны эхний улиралд 2019 оны эхний улиралтай харьцуулахад 40.8 хувиар өссөн байна. Иймээс, ХНХЯ-ны тайланд ГБХ-ийг даван туулагч нарыг яаралтай тусlamжийн утас болон цахим үйлчилгээ гэх мэт алсын зайны үйлчилгээгээр хангахыг санал болгожээ.
53. Чатботын талаар урьдчилж сурталчилгаа хийгээгүй ч ХЭҮТ-ийн чатбот 2020 оны 4-р сард ашиглалтад орсны дараа ашиглагдаж эхэлсэн байна. Ихэнх тохиолдолд чатботыг ХЭҮТ-ийн вэбсайтыг мэддэг хүмүүс ашигладаг байсан ч чатбоор дамжуулан хэд хэдэн онцгой байдлын тохиолдлыг цагдаад мэдээлсэн. Үйл ажиллагааны эхний 1 сар хагасын хугацаанд ХЭҮТ-ийн чатботод 600 хандалт бүртгэгдсэний 77.1% нь эмэгтэйчүүд, 21.7% нь эрэгтэйчүүд байв. Эхний хугацаанд ХЭҮТ 86 дуудлагад хариу өгч, 64 дуудлагыг цагдаагийн байгууллагад мэдэгдсэний 5 дуудлага нь онцгой байдлын дуудлага байсан тул хохирогчийн амь насыг авран хамгаалах яаралтай арга хэмжээ авч ажилласан байна.
54. Дараах кейс нь ХЭҮТ-ийн чатботын үйлилгээнд хамрагдсан байдлыг харуулсан жишээ юм. “Одцэцэг (нэрийг өөрчлөв) гар утсаа ашиглан чатботоос юу хийх, хаашаа явах, юу авчрах зэрэг бүх мэдээллийг унисан. ХЭҮТ Одцэцэгийн яаралтай тусlamжийн дуудлагад нэг өдрийн дотор хариу өгч, арга хэмжээ авсан. Зөвлөгч протоколын дагуу аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэхээр цагдаад мэдэгдсэн. Цагдаагийн ажилтан Одцэцэг рүү мессэж илгээхэд түүний нөхөр нь архи ууж, уурлаж гэрээсээ гараад явчихлаа гэсэн хариу мессеж ирсэн. Одцэцэг болон хүүхдүүдийн эрсдэлийн түвшин дунд түвшний эрсдэлтэй гэж үнэлгэдсэн тул нөхөр нь байхгүй хойгуур нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон. Гэтэл хамгийн ойр байрлах хоргodoх байр нь хоёр цаг явж хүрэх зйтай газар буюу Улаанбаатар хотод байсан. ХЭҮТ-өөс холбогдох цагдаагийн хэлтэс рүү ярьж Одцэцэгийг хүүхдүүдийнх нь хамт

³⁸ ХНХЯ. 2020 КОВИД-19 цар тахал Монгол Улсын ЖСХ/ГБХ, хүчирхийллийг даван туулагчийг хамгаалах үйлчилгээнд нөлөөлж буйд хийсэн түргэвчилсэн үнэлгээ. ШХА, НУБХАС

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

*оршин суугаа газраас нь аюулгүй зөөвөрлөж, хамгаалах байранд аваачих ажлыг
зохион байгуулжээ³⁹*

55. ХЭҮТ-ийн мэдээлснээр чатбот ажиллаж эхэлснээс хойшх эхний гурван сарын хугацаанд 158 шинэ хэрэглэгч чатбottой холбогдсон. Тэдгээрийн 30.4%-ийг цагдаад мэдээлэх, 16.5% нь хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх, 19.6% нь гэр бүлийн асуудлаар хуулийн зөвлөгөө авах, 14% нь гэр бүлийн маргаан, түүний дотор гэр бүлийн маргаантай асуудлаар сэтгэл зүйн зөвлөгөө авах шаардлагатай байсан бол бусад 11.4% нь ХЭҮТ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах хүсэлтэй байсан. 2022 оны эцэс гэхэд ХЭҮТ-ийн чатбот 1187 шинэ хэрэглэгчдээс хандалт хүлээн авсан бөгөөд 70.6% нь эмэгтэйчүүд, 24% нь эрэгтэйчүүд байжээ. Хэрэглэгчид нийт 6690 хандалт, харилцан яриа үлдээж, 966 асуултад хариулт авч чаджээ. Бусад хандалтанд чатбот автоматаар хариулт өгчээ. Үйл ажиллагаа явуулсан хоёр жилийн хугацаанд 451 танигдаагүй асуултуудыг илрүүлж, чатбот ажиллуулахад зориулж хөгжүүлсэн. Чатботын статистик мэдээллээс харахад танигдаагүй асуултуудын тоо буурч байгаа нь харагдаж байв.

Хүснэгт 5. ХЭҮТ-ийн чатботын хураангуй мэдээ, 2022 оны 12-р сарын байдлаар

Дуудлага	Тоо	%
Нийт дуудлага	1187	100%
Эрэгтэй	287	24.2%
Эмэгтэй	838	70.6%
Missing	62	5.2%
Нийт хандалт, харилцан яриа	7355	

56. ХЗҮХ-ийн чатбот нь 2022 оны 12-р сарын байдлаар 1705 дуудлагыг хэрэглэгчээс хүлээн авсны 68.2% нь эмэгтэйчүүд, 31.3% нь эрэгтэйчүүд байна. Нийт дуудлагын 219-ийг чатбот хариулж, хариулж чадаагүй 783-ыг нь оператор хариулжээ. Хууль зүйн зөвлөгөө авахаар 113 хүн холбогдож, 170 хүн оператор, хуулийн зөвлөхтэй ярилцахыг хүссэн байна.

Хүснэгт 6. ХЗҮХ-ийн чатботын хураангуй мэдээ, 2022 оны 12-р сарын байдлаар

Дуудлага	Тоо	%
Нийт дуудлага	1705	100%
Эрэгтэй	533	31.3%
Эмэгтэй	1163	68.2%
Missing	9	0.5%
Нийт хандалт, харилцан яриа	7410	
Цагдаад мэдээлсэн тохиолдол	0	0
Хуулийн зөвлөгөө авах	113	1.5%
Зөвлөхтэй ярилцах	170	2.2%

³⁹ АХБ. Гар яридаг: Монгол дахь даван туулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл. Фото эссе. 2022 оны 12-р сар. <https://www.adb.org/news/photo-essays/hands-talk-duty-care>- сайтаас авав.

57. ХЗҮХ-ийн чатбот нь 2022 оны 5-10 сарын хооронд 6145 хандалтыг 281 хэрэглэгчээс хүлээн авсны 82 нь шинэ хэрэглэгчид юм. Энэ хугацаанд ХЗҮХ нийт 328 иргэнд⁴⁰ буюу 204 (62.2%) эмэгтэй, 124 (37.8%) эрэгтэйд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгсөн байна. Нийт дуудлагын 223-ыг Улаанбаатар хот, 98-ыг орон нутаг, 7 дуудлагыг хилийн чанадад байгаа Монголчууд хийсэн байна. Энэ нь чатбот нь яаралтай тусlamжийн утасны дуудлагаас илүү өргөн хүрээнд хүрч чадахыг харуулж байна.

58. ХЭҮТ-ийн тайланд дурдсанаар 2022 онд чатбот хэрэглэгчдийн тоо өссөн байна. 2022 оны 10-р сараас чатбот үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, таниулах сурталчилгааг эхлүүлсний дараа чатбот хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгааг хүснэгт 7-оос харж болно.

Хүснэгт 7. ХЭҮТ-ийн чатбот хэрэглэгчид 2021-2022

Жил	Хэрэглэгчдийн тоо	Холбогдсон оператор	%
2021	373	98	26.3%
2022	901	215	23.9%
Нийт	1274	313	24.6%
2021			
Сарууд	Хэрэглэгчдийн тоо	Холбогдсон оператор	%
1-р сар	5	1	20.0%
2-р сар	6	2	33.3%
3-р сар	18	7	38.9%
4-р сар	9	2	22.2%
5-р сар	11	8	72.7%
6-р сар	39	10	25.6%
7-р сар	37	9	24.3%
8-р сар	39	10	25.6%
9-р сар	51	8	15.7%
10-р сар	43	12	27.9%
11-р сар	46	18	39.1%
12-р сар	69	11	15.9%
Нийт	373	98	26.3%
2022			
Сарууд	Хэрэглэгчдийн тоо	Холбогдсон оператор	%
1-р сар	63	18	28.6%
2-р сар	51	23	45.1%

⁴⁰ ХЗҮХ-ийн сар бүрийн дэлгэрэнгүй тайлан мэдээлэл “Эрх зүйн хөтөч” чатбот үйлчилгээний тайлан, 2022 он

3-р сар	100	29	29.0%
4-р сар	49	22	44.9%
5-р сар	34	18	52.9%
6-р сар	28	10	35.7%
7-р сар	54	18	33.3%
8-р сар	79	14	17.7%
9-р сар	89	16	18.0%
10-р сар –Хэвлэл, мэдээллийн кампанит ажил эхэлсэн	101	17	16.8%
11-р сар –Хэвлэл, мэдээллийн мессежийг түгээсэн	129	17	13.2%
12-р сарын дунд- Хэвлэл, мэдээллийн мессежийг түгээсэн	124	13	10.5%
Нийт	901	215	23.9%

59. Чатботууд нь сүүлийн 30 хоногийн өгөгдөл дүн шинжилгээ хийх аналитик функцтэй. 2022 оны 5-р сарын ХЭҮТ-ийн чатботын 30 хоногийн дүн шинжилгээнээс харахад дуудлагын гуравны нэг (34%) нь хүчирхийллийн талаар цагдаад мэдээлэх, дөрөвний нэг (25.9%) нь санал, хүсэлт илгээх, тавны нэг (20%) нь зүгээр л ярилцлага эхлүүлж, чатботын санал болгож буй сэдвүүдээс сонгож байсан бол ойролцоогоор 13% нь цахим асуулга бөглөж, 7% нь тайланг уншсан байна. 2022 оны 11-р сарын тоо баримтаас харахад хүчирхийллийн талаар мэдээлэх зорилгоор бараг ижил тооны хүмүүс холбогдож байсан ч илүү олон хүн чатбот руу хандаж асуулт үлдээх (22%) эсвэл тестийн асуулга бөглөж (24%) байгааг харуулжээ. 2022 оны 12-р сарын тоо баримтаас харахад ихэнх хэрэглэгчид зөвлөхтэй ярилцахаар утасдаж (32.6%), асуулт үлдээж (29.5%), сэтгэлзүйн зөвлөгөөний тайланг уншсан (13.2%) байна

Хүснэгт 8. ХЭҮТ-ийн чатбот үйлчилгээний тоо 2022 оны саруудын сүүлийн 30 хоногийн байдлаар (5, 11, 12-р сар)

Мэдээний хугацаа	2022 оны 5-р сар		2022 оны 11-р сар		2022 оны 12р сар	
Чатбот статистик, сүүлийн 30 хоног	Хэрэглэгчдийн тоо	%	Хэрэглэгчдийн тоо	%	Хэрэглэгчдийн тоо	%
Хүчирхийллийн талаар мэдээлэх; эсвэл цагдаад мэдэгдэх	63	34.1%	60	26%	10	7.8%
Санал, хүсэлт өгөх	48	25.9%	40	18%	14	10.9%
Ярилцлага эхлүүлсэн: зөвлөхтэй чааталсан	37	20.0%	24	11%	42	32.6%
Тестийн асуулга бөглөсөн	24	13.0%	54	24%	8	6.2%

Тайлан уншсан	13	7.0%			17		13.2%
Аауулт үлдээсэн			50	22%	41		29.5%
Нийт	185	100.0%	228		129		100%

60. Чатботын сүүлийн 30 хоногийн тайлангаас харахад (Зураг 3-ыг харна уу) ХЭҮТ-ийн чатбот хэрэглэгчид ихэвчлэн байгууллага (16%) эсвэл эксперт (7%), ХЭҮТ-ийн талаар (9%), түүний үйлчилгээ (19%), хамгаалах байр (9%) хүчирхийллийн талаар ерөнхий мэдээлэл авах (15%), бэлгийн хүчирхийллийн талаар (9%), богино хэмжээний видео үзэх (10%), хандив өгөх сонирхлоо (6%) илэрхийлэх зорилгоор холбогдсон байна. Үүнээс гадна ХЭҮТ-ийн вэбсайт нь хүчирхийллийг даван туулж байгаа хүмүүст боломжит үйлчилгээний талаар мэдээлэл авахад нь тусалдаг. *“Би ХЭҮТ ямар төрлийн үйлчилгээ үзүүлдэг болохыг мэдэхийг хүссэн. Ингээд би тэдний цахим хуудаснаас мэдээлэл авч, Улаанбаатар дах ХЭҮТ-ийн оффист очиж байсан”* (Хүчирхийллийг даван туулагч эмэгтэйтэй хийсэн ярилцлага, Булган аймаг).

61. ХЗҮХ нь ихэвчлэн хууль эрх зүйн мэдээлэл өгдөг. Тиймээс ХЗҮХ чатбот нь ЖСХ болон ГБХ-тэй холбоотой хууль эрх зүйн лавлагаа, мэдээллийг өгдөг. ХЗҮХ нь хууль зүйн мэдээлэл өгөхдөө 3 ангиллыг ашигладаг бөгөөд үүнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж зэрэг багтдаг. Хуулийн мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлээр 2 операторыг 2022 оны 5-р сард сургаж бэлтгэсэн. 2022 оны 5-9 сарын хоорондох хугацаанд 246 иргэн гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар хууль зүйн зөвлөгөө авсны 42% нь гэр бүлийн хүчирхийллийн төрөл хэлбэрийн талаар, 33% нь гэр бүл цуцлуулах үйл явц, 17% нь ХЭҮТ болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу холбон зуучлагдаж, 8% нь гэр бүлийн асуудлаар зөвлөгөө авчээ.

Хүснэгт 9. ХЗҮХ-ийн чатбotoор өгсөн хуулийн зөвлөгөө, төрлөөр

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн төрөл	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10- р сар	11- р сар	12- р сар	Нийт	%
Бие махбодийн хүчирхийллийн талаарх зөвлөгөө, мэдээлэл	12	18	10	8	9	7	7	15	86	14%
Сэтгэл зүйн хүчирхийллийн талаарх зөвлөгөө, мэдээлэл	8	9	8	8	3	10	11	10	67	11%
Эдийн засгийн хүчирхийллийн талаарх зөвлөгөө, мэдээлэл	6	5	4	1	2	5	8	15	46	8%
Бэлгийн хүчирхийллийн талаарх зөвлөгөө, мэдээлэл	12	10	5	1	5	10	4	10	57	9%
Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх талаар мэдээлэл	7	8	2	2	5	4	14	5	47	8%
Холбон зуучлалын тоо	8	14	13	17	12	24	9	10	107	17%
Гэр бүл салалтын талаарх зөвлөгөө	13	16	44	26	39	17	17	30	202	33%
НИЙТ	66	80	86	63	75	77	70	95	612	100%

62. Бэлгийн цөөнх болон эрэгтэйчүүдийг чатбот ашиглахыг дэмжих зорилгоор ХЭҮТ нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдолд нас, хүйс, бэлгийн чиг баримжаа харгалзахгүйгээр хүн бүрийг ХЭҮТ-тэй холбоо барихыг уриалсан солонгын өнгө бүхий зурагт хуудсыг чатбот дээр нэмсэн

63. Төслийн хүрээнд ХЭҮТ-ийн www.Safefuture.mn цахим хуудсыг шинэчисэн бөгөөд чатбот руу холбогдож өгсөн. Цахим хуудас ажиллаж эхэлсэн эхний хоёр сард буюу 2021 оны 9, 10-р сард тус цахим хуудсанд 338 хэрэглэгчийн 1156 хандалт бүртгэгдсэнээс 66% нь компьютер, 34% нь гар утсаа ашиглан цахим хуудас руу нэвтэрсэн байна.
64. ХЭҮТ болон ХЗҮХ нь мессеж үйлчилгээний урьдчилсан төлбөрт гар утасны дугаартай. 2021 оны 6-10 дугаар сарын хооронд ХЭҮТ мессеж үйлчилгээг зөвхөн 5 хэрэглэгч ашигласан байна. Харин 2022 оны эцсийн байдлаар ХЭҮТ 180 хэрэглэгчээс мессеж хүлээн авч, 1393 хэрэглэгчдэд ГБХ болон бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг, мэдээлэл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мессежийг түгээжээ. ХЗҮХ операторууд чатботын мессежийн функцийг ашиглан чатбottой холбогдож асуулт асууж, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл хайж буй хүмүүст зорилтот мессеж илгээдэг. Түүнчлэн ХЗҮХ нь цагдаагийн шуурхай дуудлагын утсанд ирсэн ГБХ-ийн эрсдэлтэй тохиолдуудын талаар мэдээллийг авч, мессежийн сувгийг ашиглан зорилтот мессеж илгээдэг болсон.
65. ХЭҮТ-ийн мэдээлснээр мессеж үйлчилгээний давуу тал нь: (а) интернэтгүй байсан ч мэдээлэл авах боломжтой; (б) Монгол Улсын хаанаас ч харьяалал харгалзахгүй холбогдох боломжтой; (в) Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт, харьяалал харгалзахгүй бүх оршин сууగчид хандах; (г) хүчирхийллийн янз бүрийн хэлбэрээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зааварчилгааг түргэн шуурхай түгээх; (д) утасны мессежний үйлчилгээний үр дүнд хүчирхийлэлд өртсэн хүүхэд, эмэгтэйчүүдийн цахим мэдээллийн сан бий болсон; (е) сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөхтэй холбоотой асуултад хариулах зорилтот мэдээг тогтмол шинэчлэн түгээх; (ж) зорилтот бүлэг, олон нийтэд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн эрүүл харилцааны талаар мэдээлэл өгөх мессеж илгээх зэрэг давуу талуудтай.
66. ХЗҮХ нь Цагдаагийн Ерөнхий газар, чатботын багтай хамтран чатбottой шууд холбох маягтыг боловсруулж, цагдаагийн 102, 107 дугаарын утастай холбожээ. ХЗҮХ нь шууд үйлчилгээ үзүүлдэггүй тул ХЭҮТ-ийн үйлчилгээнд холбон зуучлах чатботын функцтэй.
67. ТТ-ны хүрээнд дэмжлэг үзүүлсэн ХЭҮТ-ийн зөвлөөгчид шуурхай утсаар сард 200 гаруй дуудлага хүлээн авдаг. Зөвлөгчүүд ихэвчлэн хууль зүйн зөвлөгөө, туслалцаа (42%), сэтгэл зүйн зөвлөгөө (22%), мэдээллээр хангах (14%), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХГХГ)-ын хамгаалах байр, үйлчилгээ (5%) НЦҮТ-д (4%), хороо, сумын хамтарсан баг (ХБ)⁴¹ (2%), хуульчид (2%), цагдаагийн шуурхай утас (2%), сэтгэл зүйн болон сэтгээцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд холбон зуучлах ажлыг гүйцэтгэдэг. ХЭҮТ-ийн зөвлөгчид 2022 онд 2501 дуудлагад хариу өгсөн байна.
68. ХЗҮХ-ийн операторууд 2022 оны 5-р сараас эхэлж ажиллаж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд буюу 2022 оны 5-р сараас 12-р хүртэлх сүүлийн 6 сарын хугацаанд операторууд хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийн талаар (39%), гэр бүл цуцлах үйл явцтай холбоотой мэдээлэл, зөвлөгөө (32%) өгч, ХЭҮТ болон бусад шууд үйлчилгээ (21%) рүү холбон зуучилсан байна.

⁴¹ Нийгмийн ажилтан, цагдаа, эрүүл мэндийн ажилтнуудаас бүрдсэн хороо, сум, баг зэрэг төрийн анхан шатны нэгжүүдэд хамтарсан баг (ХБ) байдаг бөгөөд Засаг дарга нар удирддаг.

69. ХЭҮТ-ийн чатбот үйлчилгээ нь НЦҮТ болон хамгаалах байрны үйлчилгээ аваагүй байгаа хүчирхийлэлд өртсөн хохирогчийн авч болох боломжтой цорын ганц үйлчилгээ юм. Зургаан аймаг, хоёр дүүрэгт хийсэн олон нийтийн ФБЯ-ийн судалгаагаар чатбот үйлчилгээ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдыг дэмжих үйлчилгээний цоорхойг нөхөж байгааг дурьдаж байсан. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүчирхийлэгчийг түр саатуулах буюу богино хугацаанд баривчлах л цорын ганц авч байгаа арга хэмжээ гэдгийг бүх ФБЯ-т оролцогчид илэрхийлж байсан. ГБХ-ийн тохиолдолд баг, хорооны Засаг дарга, аймаг, сумын нийгмийн ажилтан, эмч, олон нийтийн цагдаагийн ажилтан зэрэг гишүүдтэй хамтарсан баг хариу арга хэмжээ авч, ар гэрийнхэнтэй нь уулзаж аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийдэг. Өндөр эрсдэлтэй тохиолдолд хүчирхийлэгчийг түр хугацаагаар баривчилдаг. Гэвч хүчирхийлэгчийг баривчлагдаад явсны дараа гэртээ үлдсэн хохирогчтой хэн ч ярилцдаггүй.
70. Дараах ишлэлүүд нь ГБХ-ийн нөхцөл байдлын жишээ юм. “Манай хөршийн нөхөр үргэлж согтуу ирдэг. Тэд нэг дагавар хүүхэдтэй айл. Энэ айл манай хөрши убраас цагдаа дуудсан. Харамсалтай нь маргааш нь суллагдаад гараад ирсэн байсан.” “Хүчирхийлэлд өртсөн эхнэртэй ярилцахад хэцүү байгаа тул нөхрөөсөө сална гэж байна лээ. Гэхдээ л нөхөр нь гэрт нь ирдэг хэвээр байна” (Хөдөөгийн сумын 35-аас доош насын эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 1.2, 2022 оны 10-р сар)
- “Манай нөхөр 30 хоног аймгийн төвд баривчлагдсан. Гэтэл тэр буцаж ирээд сарын турши үнэгүй хоол идчихээд ирлээ л гэж хэлсэн ... түүнд өөр ямарч өөрчлөлт гараагүй байсан” (Хөдөөгийн сумын 35-аас дээш насын эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ-4, 2022 оны 10-р сар)
71. Олон нийтийн ФБЯ хийх үед хохирогч өөрт тохиолдсон явдлаа хэн нэгэнтэй ярьсан тохиолдол эсвэл ямар нэгэн дэмжлэг авсан талаар мэдээлээгүй. Хохирогчийн ярьсанаар “Би зодуулж, нөхрөөсөө салсны дараа бутэн жил болсон явдлын талаар хэнд ч хэлж байгаагүй. Хэрэг явдлыг бодохоор л уйлмаар санагддаг байсан” (Хөдөөгийн сумын 35-аас дээш насын эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ-3, 2022 оны 11-р сар).
72. Аймаг, сумын хэмжээнд ГБХ-ийн хохирогчдод сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн дутмаг байгаа нь дээрх жишээнүүдээс илт харагдаж байна. Хамтарсан багийн гишүүд хохирогчид дэмжлэг үзүүлэх хангалттай ур чадвар, мэдлэг эзэмшээгүй байна. Мөн зарим багийн Засаг дарга нар ГБХ-ийн талаар ойлголт муу эсвэл үгүйсгэх хандлагатай байна. Тухайлбал нэг багийн засаг дарга “Манай багт гэр бүлийн хүчирхийлэл байдаггүй” гэх маягаар хайнга хандаж байсан. Сумын хамтарсан багийн зарим ажилтнууд ГБХ-ийн хохирогчид сэтгэл зүйн дэмжлэг хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байсан ч орон нутагт мэргэжлийн сэтгэл зүйч байдаггүй гэж байв. Гэхдээ сэтгэл зүйн дэмжлэгийн талаар ойлголт хангалтгүй тул “хосуудын зөвлөгөө нь ГБХ-ийн асуудлыг шийднэ” гэж буруу ойлгож байсан. (Сумын хамтарсан багийн гишүүнтэй хийсэн уулзалт, 2022 оны 10-р сар).
73. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд болон тэдний ар гэрийнхэн гомдол гаргах талаар эрх зүйн мэдээлэл, дэмжлэгийг хаанаас авахаа мэдэхгүй байдгийг зургаан аймаг, хоёр дүүрэгт хийсэн ФБЯ-т оролцогчид мэдээлсэн. Хуульд заасны дагуу хүчирхийллийн тохиолдолд гэр бүл цуцлах хүсэлтийг эвлэрэх хугацаа өгөлгүйгээр хялбаршуулсан байдлаар шийддэг ч ГБХ-ийг даван туулагч олон эмэгтэйчүүд гэр бүл цуцлуулах өргөдөл гаргахтай холбоотой олон бэрхшээлтэй тулгардаг байна. Эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаас зарим ишлэл татвал:

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

“Миний хуучин нөхөр маш их хүчирхийлдэг хүн байсан. Одоо бол би түүнээс тусдаа шинэ хамтран амьдрагчтайгаа амьдардаг. Би хүчирхийлэгч нөхрийнхөө зан авирыг олон удаа мэдээлж байсан ч одоо хүртэл гэрлэлтээ албан ёсоор салгаж чадахгүй байна” (Хөдөөгийн сумын 35 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ-3, 2022 оны 10-р сар). “Би салах өргөдлөө өгсөн. Харин салах өргөдлөө эхэлж өгсөн хүн нь тодорхой хэмжээний төлбөр төлөх ёстойюм байна лээ. Би тэр мөнгийг төлж, салах өргөдлөө өгсөн. Гэсэн ч шүүхээс бидэнд эвлэрэх хугацаа өгсөн байгаа” (Хөдөөгийн сумын эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 11-р сар)

74. Харамсалтай нь эдгээр эмэгтэйчүүдийн хэн нь ч ХЗҮХ-ийн чатбот үйлчилгээний талаар сонсоогүй байсан. Ер нь хууль эрх зүйн мэдлэг, тэр дундаа ГБХ-ийн үеийн хууль эрх зүйн зохицуулалтын талаарб мэдлэг дутмаг байгаа нь Монгол Улсад нийтлэг тулгамдаж буй асуудал юм. ХЗҮХ нь орон нутагт салбаргүй тул гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх боломж орон нутагт байхгүй байна.

Цахим дээрэлхэлт зэрэг хүчирхийллийн шинэ хэлбэрийг шийдвэрлэх цахим шийдлүүдийг боловсруулах хакатон тэмцээнийг зохион байгуулах

75. ТТ нь шинээр нэмэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, ялангуяа цар тахлын үед улам бүр нэмэгдэж буй цахим дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэх шинэ шийдлүүдийг тодорхойлох хакатоныг ивээн тэтгэсэн.
76. **Явц.** Хакатоныг Монголын Mass Медиа (МММ) "Старт-Ап" ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тэмцээнд оролцохоор 72 баг Google маягт дээрхх цахим орчин дах бэлгийн хүчирхийллийн талаарх асуултад хариулж бүртгүүлсэн. Эхний шатны шалгаруулалтад 21 баг шалгарч, "Старт-Ап" ТББ-аас зохион байгуулсан загварчлах сэтгэлээ, төслийн санал боловсруулах, саналаа танилцуулах талаарх сургалт, "Хөөрхөн зүрх" ТББ-аас цахим хүчирхийллийн талаарх ойлголтыг өгөх сургалтуудад хамрагдсан. Энэ 21 багаас 5 баг нь тэмцээнээ орхисон тул хакатон 16 багтай үргэлжилсэн. Баг бүр цахим орчин дах бэлгийн дарамт, дээрэлхэлтийн талаарх танилцуулга, цахим бэлгийн дээрэлхэлтийн талаарх статистик мэдээлэл, дизайн, санаагаа илэрхийлэх арга гэсэн сэдвүүдээр дөрвөн төрлийн сургалтад хамрагдсан. Баг тус бүрд зөвлөгөө өгч, эцсийн шалгаруулалтад 24 цагийн дотор цахим дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэх шийдлүүдийн талаар шийдлийн саналаа боловсруулсан. Эцсийн шатанд хоёр баг шилдгээр тодорсон байна.
77. Хоёрдугаар шатанд шалгарсан хоёр загвар нь: (а) "Тарзов" багийн боловсруулсан Цагдаагийн байгууллагатай холбох, цахим дээрэлхэлтийг бүртгэх мэдээллийн сантай бүрэн холбох боломжтой, чатбот функцээр үнэ төлбөргүй өөрийн үнэлгээ хийх функц бүхий вэбд суурилсан "Онлайн SOS" бэлгийн дарамтын талаар мэдээлэх платформ, (б) "#MeToo" багийн боловсруулсан тоглоомын загвар ашиглан эрсдэлийн үнэлгээ хийх онлайн хэрэглүүртэй Монголын нөхцөл зориулсан #MeToo брэнд. Хакатон хөгжүүлэгчид АХБ-ны мэдээллийн технологийн хэлтсээс хакатон зохион байгуулах зорилгоор боловсруулсан Оюуны өмчийн эрхийн тухай АХБ-ны стандарт маягтанд гарын үсэг зурсан байна. Хэвлэл мэдээллийн зөвлөх баг хакатоны сурталчилгааг бэлтгэсэн бөгөөд энэ нь хакатоны зорилго, хүлээгдэж буй үр дүнг биш түүний зохион байгуулалтын тал дээр голчлон төвлөрсөн байсан. Чатбот боловсруулсан "Anduu Lab" компани нь #stopcyberbullying хааштаг-ийг үнэгүй ботуудаараа дамжуулан хакатоныг сурталчилжээ.

78. Үр нөлөө. Хакатоны үр дүнд 21 багийн 100 орчим мэдээлэл технологийн мэргэжилтэнүүд цахим дээрэлхэлт, онлайн бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэгээ дээшлүүлсэн. Хакантонд шалгарсан хоёр баг ахиад боломж олдсон тохиолдолд өөрсдийн санал болгосон загваруудаа цаашид хөгжүүлж, хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн.

ГБХ-ийн хохирогчдод анхан шатны тусlamж үзүүлдэг мэргэжилтнүүдэд зориулсан онлайн сургалтыг зохион байгуулах

79. КОВИД-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг дэмжих, хамгаалах байрны чадавхийг бэхжүүлэх нь ТТ-ын зорилтуудын нэг байсан. Энэхүү зорилгод хүрэхийн тулд Үр дүн 1-ийн хүрээнд анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд, хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор худалдан авалтын ажлыг хийсэн. Мөн шүүх эмнэлгийн чадавхийг сайжруулах, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой ажлуудыг Үр дүн 2-ын хүрээнд төлөвлөсөн. Сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтыг НЦҮТ/ТХБ-ны мэргэжилтэнүүд, цагдаагийн сэтгэл зүйчид зэрэг анхан шатны тусlamж үзүүлэгчдэд зохион байгуулжээ.

80. Явц. Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээр 2 удаагийн сургалтыг НЦҮТ болон ТХБ-ны ажилтнуудад зохион байгуулсан бөгөөд үүнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ/ТХБ-уудын 175 ажилтан хамрагдсан. Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээр 3 өдрийн тусгайлсан сургалтыг мөн зохион байгуулж, улсын хэмжээнд цагдаагийн 60 сэтгэл зүйч хамрагджээ.

81. НЦҮТ, ТХБ-ны ажилтнуудад зориулсан сургалтыг 2021 онд “Хөөрхөн Зүрх” ТББ-аас онлайн/онлайн хэлбэрээр зохион байгуулсан. Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан танхимиын сургалтыг Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн (ХССХ) 2022 онд зохион байгуулсан.

82. НЦҮТ/ТХБ-ны анхан шатны тусlamж үзүүлэгчдэд болон тусгай үүргийн байгууллагуудад зориулсан Сэтгэцийн эрүүл мэндийн гарын авлагыг боловсруулсан. Уг гарын авлагыг төслийн Техникийн зөвлөх баг болон АХБ-ны баг хянаж, баталсан байна.

83. НЦҮТ/ТХБ-ны ажилтнуудад зориулсан сургалт нь дараах модулиудаас бүрдсэн.

Эхний өдрийн сургалт

1. Сэтгэл хөдлөлөө таньж, түүнийгээ эрүүлээр удирдах нь
2. Ажил үүрэг ба сэтгэл хөдлөл /КОВИД-19-ийн үеийн сэтгэл зүйн асуудал ба сэтгэл хөдлөл/
3. Стресс гэж юу вэ; архаг стресс гэж юу вэ?
4. Стресс нь бие махбодь, оюун санаа, зан үйлд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хоёр дах өдрийн сургалт

1. Стрессийг хэрхэн удирдах вэ?
2. Ядрах, ажлаас залхах синдромоос хэрхэн урьдчилан сэргийлэх, даван туулах вэ?
3. Сэтгэцийн эрүүл мэндэд анхаарлаа хандуулах; өөртөө анхаарал тавих нь
4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хүчирхийлэлд өртсөн хүмүүст үйлчилгээ үзүүлэх ёс зүйн дүрэм

84. Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан “Стресс менежмент” сургалтын гарын авлагад дараах модулиуд багтсан болно

 1. Стрессийг ойлгох нь
 2. Стрессийг даван туулах нь
 - 2.1 Стрессийг даван туулах стратеги, арга хэрэгсэл
 - 2.2 Стрессээс зайлсхийх сэтгэл зүйн аргууд
 - 2.3. Стрессстэй тэмцэх сэтгэлзүйн аргууд
 - 2.4 Стрессийг даван туулсны дараа ашиглах сэтгэл зүйн аргууд
 3. Сэтгэл зүйн оношлогооны хэрэгсэл
 - 3.1 “Байшин-Мод-Хүн” проекцийн арга
Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн байшин-мод-хүний зураг
 - 3.2. Өнгөний тест

85. **Үр нөлөө. (1) НЦҮТ/ТХБ-ын ажилтнуудад зориулсан сургалт.** Үр нөлөөний үнэлгээгээр НЦҮТ/ТХБ-д боловсон хүчний халаа сэлгээ өндөр байгаа нь харагдсан. Судалгаанд хамрагдсан 29 хүний 90 хувь нь төслийн хүрээнд зохион байгуулагдсан сэтгээцийн эрүүл мэндийн онлайн сургалтад хамрагдсан байв. Харин ФБЯ-д оролцсон анхан шатны үйлчилгээ үзүүлэгч 20 ажилтнаас 7 (35%) нь сургалтад хамрагдсан бол 13 (65%) нь сургалтад хамрагдаагүй байна. ФБЯ-ийн оролцогчдын 50 хувь нь саяхан шинээр ажилд орсон байсан. ФБЯ-д оролцогчдын ярьсан зарим ишлэлийг доор харуулав. “Манай салбарын хүний нөөцөд их өөрчлөлт орж байна. Ийм стрессийн менежмент, сэтгээцийн эрүүл мэндийн чиглэлээр сургалтыг ойр ойрхон давтамжтай явуулж байх ёстой. Түүнчлэн шинээр орж ирж буй боловсон хүчнийг эдгээр сэдвээр тогтмол сургах хэрэгтэй” (Өвөрхангай аймгийн ГБХЗХГ-ийн ажилтнуудтай хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар). “Сургалтад хамрагдсан манай сэтгэл зүйч ажлаасаа гарсан. Тэр одоо сургуульд сэтгэл зүйчээр ажиллаж байна” (Баянхонгор аймгийн ТХБ-ны ажилтнуудтай хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар). “Дахиад яг энэ сэдвээрээ давтан явуулбал зүгээр байна. Ерөнхийдөө сургалтыг анх эхлээд сонсох, хоёр дах удаагаа дахин сонсох, тэгээд 1 жилийн турш ажилдаа хэвшүүлэхэд сургалтын үр нөлөө өөр байдаг. (Баянхонгор аймгийн ТХБ-ны ажилтнуудтай хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар)”.

86. Судалгаанд хамрагдагчид бүгд энэхүү сургалтыг хэрэгтэй байсан гэж үзсэн ба 92.3 хувь нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үзсэн. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь сургалтыг цаг үеэ олсон (96.2%) гэж үзсэн бол 84.6% нь анх удаагаа ийм төрлийн сургалтад хамрагдсан гэжээ. КОВИД-19-ийн хямралын үеэр ХНХЯ-аас хийсэн судалгаагаар “Олон нийтийн өмнө тулгарч буй нийтлэг сорилтуудын хажуугаар НЦҮТ/ТХБ-ны ажилтнууд нь өдөр бүр дор хаяж 3-5 кейсийг шийдвэрлэж, ажлын ачаалал нь нэмэгдсэнээс болж стресс ихэссэн. Стресс, бухимдал хуримтлагдаж, ажлын бутээмж, хувийн амьдралд нь нөлөөлсөн”⁴² гэж мэдээлж байжээ.

Хүснэгт 10. НЦҮТ, ТХБ-ны ажилтнуудын анкетийн судалгааны үр дүн

⁴² MSPL, SDC and UNFPA. 2020. Rapid assessment of the impact of Covid-19 on the GBV/DV situation and survivor protection service in Mongolia. Page,9. Report.

Асуултууд	Сэтгэл зүйч	ГБХЗХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН	Нийгмийн ажилтан	ТХБ-НЫ ЗОХИЦУУЛАГЧ	Эзлжийн ажилтнууд болон бусад	Нийт N=29
1. Та сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтад хамрагдсан уу?	6 75.0%	7 100.0%	6 85.7%	4 100.0%	3 100.0%	26 90%
2. Та сургалтаа дуусгасан уу (2/3 өдрийн сургалтад хамрагдсан)?	6 100.0%	5 71.4%	6 100.0%	3 75.0%	2 66.7%	22 84.6 %
3. Танд сургалт хэрэгтэй байсан уу?	6 100.0%	7 100.0%	6 100.0%	4 100.0%	3 100.0%	26 100%
4. Сургалт таны хэрэгцээнд тулгуурласан байсан уу (энэ нь танд хэрэгтэй гэж бодож байсан уу)?	6 100.0%	5 71.4%	6 100.0%	4 100.0%	3 100.0%	24 92.3 %
5. Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн сургалтад анх удаа оролцож байна уу?	3 50.0%	6 85.7%	6 100.0%	4 100.0%	3 100.0%	22 84.6 %
8. Сургалт КОВИД-19-ийн үед зохион байгуулагдсан нь цаг үеэ олсон гэж үзэж байна уу?	6 100.0%	7 100.0%	6 100.0%	4 100.0%	2 66.7%	25 96.2 %
9. Сургалтын дараа таны ажлын гүйцэтгэлд ямар нэгэн нөлөөлөл ажиглагдсан уу?	6 100.0%	5 71.4%	6 100.0%	4 100.0%	3 100.0%	24 92.3 %
10. Сургалтын зохион байгуулалт сайн байсан уу	6 100.0%	6 85.7%	6 100.0%	4 100.0%	1 33.3%	23 88.5 %
11. Сургалтын арга хэлбэрийг (онлайн) үр дүнтэй гэж үзэж байна уу? тийм	3 50.0%	2 28.6%	3 50.0%	4 100.0%	3 100.0%	15 57.7 %
11.b Сургалтын арга хэлбэр үр дүнтэй байсан гэдэгт ИТГЭЛГҮЙ БАЙНА.	2 33.3%	4 57.1%	3 50.0%	0 0.0%	0 0.0%	9 34.6 %
14. Сургалтын дараа ажлын хэв маягаа өөрчилсөн үү?	0 0.0%	1 14.3%	1 16.7%	2 50.0%	1 33.3%	5 19.2 %

87. ХШҮ-ний зөвлөхийн сургалтын дараа нийт 7 НЦҮТ/ТХБ-ны ажилтнуудтай хийсэн ярилцлагад тэд үйлчлүүлэгчиддээ анхаарал халамж тавидал ч өөрсдийн сэтгэцийн эрүүл мэндийн талаар ярилцах, дүн шинжилгээ хийх боломж хэзээ ч гарч байгаагүй гэж ярьсан байна.

88. Үнэлгээний судалгаанд оролцогчдын 88.5% нь сургалтыг сайн зохион байгуулсан гэж үзсэн ч цахим сургалтын хэлбэрийг оролцогчдын 60% нь л үр дүнтэй гэж үзэж, 35% нь үр дүнтэй гэдэгт итгэлгүй байна гэжээ. Оролцогчдоос ирсэн хамгийн түгээмэл санал бол "ижил төрлийн сургалтыг танхимаар зохион байгуулж, стрессийг бууруулах илүү олон арга техникийг багтаасан" байх нь зүйтэй байна гэсэн. Анхны төлөвлөж байснаар сургалтад оролцогчдыг хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод авчирч танхимиын сургалт явуулах байсан. Гэвч КОВИД-19-

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

ийн үеийн зорчих хөдөлгөөний хязгаарлалтаас шалтгаалан сургалтыг цахимаар зохион байгуулжээ.

89. Сургалт сонирхолтой байсан хэдий ч ажлын цагаар зохион байгуулсан тул сургалтад анхаарлаа бүрэн төвлөрүүлж чадаагүйгээ зарим оролцогчид хэлж байлаа. Тухайлбал, нэг мэргэжилтэн сургалтад оролцож байхдаа яаралтай тусlamжийн утсанд хариулах ёстой байсан гэж байв. Өөр нэг мэргэжилтэн хамгаалах байранд байгаа хэд хэдэн насанд хүрээгүй үйлчлүүлэгчийг харж хандаж байсан гэж байв. Энэ үедээ бүгд цахим сургалтад нэвтэрч, сургалтад “оролцож буй” мэт харагдаж байсан байна. Тухайлбал, сургалтад хамрагдсан ажилтаны ярьснаар: “Манай хамгаалах байранд 7-8 хүүхэд байрлаж байсан болохоор оффис дээр сургалтад хамрагдаж байхдаа сургалтад анхаарлаа төвлөрүүлж чадахгүй, хэцүү байсан. Дээрээс нь би тэр өдөр шүүх хуралд хүртэл оролцох ёстой байсан. Иймд энэ төрлийн сургалтыг “нүүр тулсан” хэлбэрээр эсвэл цөөн оролцогчтойгоор зохион байгуулах нь зүйтэй” гэсэн юм. (Аймаг 1.0 Хамгаалах байрны ажилтнуудтай хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар).
90. Мөн “Хөөрхөн Зүрх” ТББ-ын тайлагнааснаар сургалтад оролцогчдын тоо олон байсан тул оролцогчид бие биетэйгээ танилцах, асуулт асуух, санал бодлоо илэрхийлэх цаг хязгаарлагдмал байсан гэж үзсэн. Тиймээс тус ТББ сургалтад оролцогчдыг өөрсдийнхөө тухай товч танилцуулга, санал хүсэлт, асуултаяа чатаар ирүүлэхийг хүссэн.
91. НЦҮТ/ТХБ-ны анхан шатны тусlamж үзүүлэгчдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний гарын авлагыг урьдчилан бэлтгэсэн нь маш хэрэгцээтэй байсан. Гэсэн хэдий ч гарын авлагыг НҮЦТ, түр хамгаалах байранд тараагаагүй нь энэ ажлыг үр дүнгүй болгосон. Учир нь баймаг, нэг дүүрэгт хийсэн үр нөлөөний үнэлгээний ярилцлагын үеэр ХЭҮТ-ийн харьяа Баянхонгор аймгийн хамгаалах байр л гарын авлагыг хүлээн авсан тухай мэдээлсэн. Бусад НЦҮТ/ТХБ-үүд гарын авлагыг хүлээж аваагүй. Баянхонгор аймагт ч гэсэн хамгаалах байрны менежер л гарын авлагыг хүлээн авсан болохоос тэрээр бусад ажилтнуудтай хуваалцах ёстой эсэхээ мэдээгүй байсан гэж байв.
92. Судалгааны үр дүнгээс харахад сургалтад оролцогчдын дийлэнх нь (85%) нь сурсан мэдсэнээ, тухайлбал, стрессийг удирдах арга техник, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах аргуудыг ажилдаа ашигласан гэжээ. Олонх мэргэжилтэнүүд өөрсдийн эзэмшсэн өөрийгөө стрессээс хамгаалах арга, хохирогчдод зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх аргуудыг ашиглан хамтран ажиллагчиддаа зориулсан сургалт зохион байгуулжээ. Доорх эшлэлээс харахад ФБЯ-д оролцогчид энэ сургалтыг хэрэгтэй бөгөөд цаг үеэ олсон гэж дүгнэсэн.

“Эхний өдөр тал, 2 дахь өдөр нь бүтэн суусан. Мэдээлэл нь тухайн цаг үетэй тохирсон шинэлэг сонирхолтой байсан. Энэ сургалт надад хэрэгтэй байсан. Сэтгэлзүйч сургагч багш нар дуртай дуугаа сонсох, зураг харах гэх мэт тайвшрах аргуудыг сайн тайлбарлаж өгсөн. Энэ нь үйлчлүүлэгчийн хүнд асуудлыг сонсоод стрессст ордоог бидэнд тайвшралыг олоход маш их дэм болдог”. (Аймаг-2, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар)

“Би болохоор ээрэг сэтгэл хөдлөлөө таних, ажлаас халирах хам шинжийн шинж тэмдэгүүд, ажил мэргэжлийн шаардлага ба сэтгэл хөдлөл, урьдчилан сэргийлэх ба даван туулах аргууд ба ковидын үед ажлын стрессээ хэрхэн удирдах гэсэн сэдвүүдийг санаж байна. Энэ сургалтад суусан ч гэсэн бид нар Ковидын үед уртасгасан цагаар ажиллаж, стресс ихтэй байсан болохоор

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

*сэтгэлзүйчээрээ өөрсдийн хэв шинж стрессийн түвшинг тодорхойлуулж
байсан. Мөн хүний зан чанарт тохируулж харьцах, өөрийгөө хянах зэрэг
аргуудыг хэрэглэж сурсан” (Аймаг-2, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ФБЯ,
2022 оны 10-р сар)*

*“Сургалтаас стрессээ удирдаж сурсан нь миний ажлын бүтээмжид сайнаар
нөлөөлсөн. Жишээлбэл, миний санааг зовоож байгаа бүх зүйлийг цаасан дээр
бичиж, тэр цаасыг урж хаядаг. Эсвэл би хүнгүй газар очоод чангаар хашгирдаг.
(Аймаг-1 ГБХЗХГ-ын ажилтнуудтай хийсэн ФБЯ, 2022 оны 10-р сар)*

93. **Үр нөлөө.** (2) Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сургалт. ТТ-ны хүрээнд зохион байгуулсан Стресс менежмент, сэтгэцийн эрүүл мэндийн талаар цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сургалт нь энэхүү зорилтот бүлэгт зориулан зохион байгуулсан анхны сургалт байлаа. Сургалтад 60 сэтгэл зүйч хамрагдсан ба аймгуудын цагдаагийн хэлтэсийг төлөөлж 21, Улаанбаатар хотын 9 дүүргээс 9, Цагдаагийн газрын харьяа хэлтэс албадаас 30 сэтгэл зүйч оролцсон. Судалгаанд хамрагдагдсан цагдаагийн сэтгэл зүйчдийн 50 хувь нь цагдаагийн байгууллагад 0-3 жил, 13 хувь нь 4-6 жил, 20 хувь нь 7-10 жил, 17 хувь нь 11-ээс дээш жил ажилласан туршлагатай байсан. Судалгаанд оролцогчид одоогийн албан тушаал дээрээ дунджаар 5.5 жил ажилласан туршлагатай байсан.
94. Сургалтын үнэлгээний тайлангаас хараад цагдаагийн сэтгэл зүйчдийн стрессийн түвшинг маш бага, бага, дунджаас доогуур, дунд, дунджаас дээш, их, маш өндөр гэсэн 7 шатлалаар хэмжжээ. Үнэлгээгээр 76% нь дунджаас доогуур, 6% нь дундаж, 19% нь дунджаас дээгүүр, 17% нь өндөр стресстэй, 2% нь маш өндөр стресстэй байсан байна. Сургалтын өмнөх болон дараах үнэлгээгээр сургалтад оролцогч эмэгтэйчүүдийн мэдлэг 38%- 93%, эрэгтэйчүүдийн мэдлэг 38%-95% болж өссөн байна. Үр нөлөөний үнэлгээний асуултгыг нийт сургалтад оролцогчдын 29 нь бөглөсөн. Үнэлгээний багийн гишүүд цагдаагийн 3 сэтгэл зүйчтэй уулзаж, дэлгэрэнгүй ярилцлага хийсэн.

Хүснэгт 11. Анкетийн судалгааны үр дүн, хүйсээр

Асуултууд	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
1. Та сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн цахим сургалтад хамрагдсан уу?	5	22	27
% хүйсээр	%	91.7%	93.1%
2. Та сургалтаа бүрэн дуусгасан уу (3 өдрийн сургалтад хамрагдсан уу)?	5	19	24
% хүйсээр	100.0%	79.2%	82.8%
3. Танд сургалт хэрэгтэй байсан уу?	5	22	27
% хүйсээр	100.0%	91.7%	93.1%
5. Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн сургалтад анх удаа оролцож байна уу?	4	12	16
% хүйсээр	80.0%	50.0%	55.2%
9. Сургалтын дараа таны ажлын гүйцэтгэлд ямар нэгэн нөлөөлөл ажиглагдсан уу?	4	19	23
% хүйсээр	80.0%	79.2%	79.3%
10. Сургалт сайн зохион байгуулагдсан уу?	5	22	27
% хүйсээр	100.0%	91.7%	93.1%

11. Сургалтын аргыг (онлайн) үр дүнтэй гэж үзэж байна уу?	3	18	21
% хүйсээр	60.0%	75.0%	72.4%

95. Дээрх Хүснэгт 11-ээс харахад нийт оролцогчдын 82.8 хувь нь сургалтад бүрэн хамрагдсан байна. Тэдний тал орчим хувь нь өмнө нь ижил төстэй сургалтад хамрагдаж байсан хэдий ч судалгаанд хамрагдагчдын 93 орчим хувь нь тус сургалтыг хэрэгтэй байсан гэж үзсэн байна. Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь сургалт нь тэдний ажлын гүйцэтгэлд тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлсөн гэдэгтэй санал нийлж, 93 хувь нь сургалтыг сайтар төлөвлөсөн гэж үзсэн байна.

96. Ярилцлагын үеэр оролцогчдын хамгийн сайн санаж, ажилдаа ашигласан сэдэв бол стрессыг удирдах үндсэн ойлголтууд, стресс тайлах дасгалууд болон аргууд байв. Дараа ишлэл нь сургалтад хамрагдагсан цагдаагийн сэтгэл зүйчийн сэтгэгдэл юм: *“Би анх удаа стресс менежмент, сэтгээцийн эрүүл мэндийн сургалтад хамрагдсан. Өнгөний тест, проекктив тестийг ашиглан бид өөрсөд дээрээ дадлага хийсэн. Хэдийгээр би тестийг мэддэг ч гэсэн тийм нарийвчилсан маягаар сураагүй байсан юм билээ. Тиймээс тестүүдийн талаар илүү сайн ойлгох нь бидэнд маш хэрэгтэй байсан.”* (Аймаг-1, цагдаагийн сэтгэл зүйчтэй хийсэн ярилцлага, 2022.10-р сар).

97. Цагдаагийн сэтгэл зүйчийн үүрэг бол цагдаагийн алба хаагчийн сэтгээцийн эрүүл мэндэд анхаарал тавих явдал юм. Сургалтад хамрагдсан цагдаагийн бүх сэтгэл зүйчид сэтгэл судлалын чиглэлээр боловсрол эзэмшсэн, олон жилийн ажлын туршлагатай байна. Гэсэн хэдий ч одоогоор цагдаагийн сэтгэл зүйчид цагдаагийн алба хаагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхээс илүүтэйгээр цагдаагийн хэлтэст захирагааны ажлыг голчлон гүйцэтгэж байна. Сургалтын дараа сэтгэл зүйчид цагдаагийн ажилтнуудын сэтгээцийн эрүүл мэнд, стрессст илүү анхаарч эхэлсэн. Түүнчлэн сэтгэл зүйчид цагдаагийн алба хаагчдын дунд сургалт семинар, бүлгийн ярилцлага зохион байгуулж, алба хаагчдад зөвлөгөө өгөх тест, хэрэгслийг ашиглаж байна. Ярилцлагын үеэр нэгэн сэтгэл зүйч цагдаа нар тэр бүр сэтгэл зүйн зөвлөгөө авдаггүй гэдгийг дурссан. Тиймээс цагдаагийн алба хаагчидтай ажиллах хамгийн үр дүнтэй арга бол бүлгийн хэлэлцүүлэг, сургалт хийх гэжээ.

IV. АНХААРАХ ГОЛ АСУУДЛУУД

98. Үр нөлөөний үнэлгээгээр Монгол Улсад гэр булийн хүчирхийллийн эсрэг тэмцэх үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудлыг гаргаж ирсэн.

A. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

99. Олон нийттэй хийсэн ФБЯ болон хэрэгжүүлэгч талуудтай хийсэн ярилцлагаас харахад, ялангуяа аймаг, орон нутгийн түвшинд, эмэгтэйчүүд одоо байгаа үйлчилгээний талаар мэдлэг хомс байна. Зургаан аймаг, хоёр дүүргийн ФБЯ-аас дүгнэхэд гэр булийн хүчирхийлэлд өртсөн иргэд хуулийн дагуу эдлэх ёстой эрхээ мэддэггүй, мөн хаанаас мэдээлэл авахаа ч мэддэггүй байна. Гэр булийн хүчирхийлэл үйлдэгчээс хамгаалах арга хэмжээ авах эрх зүйн мэдлэг дутмаг байдал нь гэр булийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид хүчирхийлэгчтэйгээ хамт үлдэхэд хүргэдэг. Үнэлгээнд оролцсон эмэгтэйчүүдийн зарим нь хүчирхийлэлд өртөж тусдаа амьдарч байгаа ч гэрлэлтээ цуцлуулах өргөдөл гаргах хуулийн

процессын талаар мэдээлэлгүй байсан. Олон хүмүүс энэ процессыг төвөгтэй гэж үзэждэг байна.

100. Гэр бүлийн хүчирхийллийн үед авч хэрэгжүүлж буй цорын ганц арга хэмжээ бол хүчирхийлэгчийг түр хугацаагаар баривчлах явдал гэдгийг бүх ФБЯ-ууд тодорхойлсон. Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үздэг ч давтан үйлдсэн этгээдэд эрүүгийн хуулийн дагуу хэрэг үүсгэж хариуцлага тооцдог. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулахаар хуульд заасан байдаг ч практик дээр хэрэгждэггүйг эмэгтэйчүүдийн ба эрэгтэйчүүдийн бүлгүүд хэлж байв. Нөхөр нь богино хугацааны баривчилгааг “30 хоногийн үнэгүй хоол идээд ирлээ” гэж хүлээж авсан тухай нэгэн эмэгтэй ярьж байв. Энэ нь хүчирхийллийн үеийн хариу арга хэмжээ үр дүнгүй байгааг харуулж байгаа бөгөөд үүний үр дүнд хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийллийн үйлдэлээ дахин үйлдэх боломжийг олгож байна.
101. Олон нийтийн төлөөлөлтэй хийсэн ФБЯ нь хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг үйлчилгээ дутмаг байгаа гэдгийг харуулсан. Өөрөөр хэлбэл, хохирогчдод зөвлөгөө өгөх гэм тэр ямар нэг дэмжлэг огт үзүүлдэггүй. Гол асуудал нь сум, аймгийн хэмжээнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхэд мэргэжлийн ур чадвар дутмаг байгаатай холбоотой. ГБХ-ийн тохиолдлуудад хариу арга хэмжээ авах, гэр бүлийн эрсдлийн үнэлгээ хийх үүрэг бүхий хамтарсан багийн гишүүдийн хохирогчдод дэмжлэг үзүүлэхэд шаардагдах ур чадвар, мэдлэг дутмаг байна.

В. ГБХ-ИЙН ХОХИРОГЧИДТОЙ АЖИЛЛАДАГ НЦҮТ, ТХБ, ЦАГДААГИЙН АЖИЛТНУУД БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

102. Үр нөлөөний үнэлгээний үр дүнгээс хараад НЦҮТ, ТХБ-ны ажилтнуудын дунд ажлаас халшрах, урам зориггүй болох зэрэг нь боловсон хүчний байнга өөрчлөгдөх шалтгаан болж байна. Ажилтнууд байнга солигддог нь байгууллагуудын чадавх болон ГБХ-ийг даван туулагчид төрүүлэх итгэлцлийг бий болгох харилцаанд нөлөөлдөг. ФБЯ-ын мэдээлэл цуглуулах ярилцлагад оролцсон НЦҮТ болон ТХБ-ны ажилтнуудын тал хувь нь шинэ ажилтнууд байсан (ФБЯ-д 20 хүн оролцсоны 10 нь шинэ ажилтнууд). ТТ-ын дэмжлэгийн хүрээнд сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтад хамрагдсан хэд хэдэн ажилтан НЦҮТ/ТХБ-д ажиллахаа больсон байв.
103. Цагдаагийн сэтгэл зүйчдийн мэдээлснээр ГБХ-ийн хохирогчидтой ажилладаг цагдаагийн ажилтнууд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авдаггүй байна. Үнэлгээний явцад шалтгааныг задлан шинжлээгүй ч энэ нь цагдаагийн алба хаагчид сэтгэл зүйн эрүүл мэнд, стресс менежментийн ач холбогдлыг дутуу үнэлж байгаатай холбоотой байж болох юм.
104. Үүний зэрэгцээ ТТ-ны хүрээнд зохион байгуулсан сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтад хамрагдсан НЦҮТ, ТХБ-ны ажилтнууд, цагдаагийн сэтгэл зүйчид сургалтыг чухал бөгөөд үр дүнтэй гэж үзэж байна. Ярилцлагад хамрагдагчдын хэлснээр сургалт нь өөртөө цаг гаргаж, өөрийн сэтгэцийн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавихад тусалсан төдийгүй энэ нь эргээд ГБХ-ийг даван туулагчтай харилцах харилцаанд эерэгээр нөлөөлж байсан. ФБЯ-д болон судалгаанд оролцогчид өөрсдийн сэтгэцийн байдлын талаар ярилцах “хэн нэгэн хүн байхгүй” гэдэгтэй санал нэг байв.

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

105. Үнэлгээгээр сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, стресс менежментийн чадавхийг бэхжүүлэх, түүнчлэн ГБХ-ийн даван туулагчтай ажилладаг байгууллагуудад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чадвар дутмаг байгааг баримтжуулсан. Сэтгэцийн эрүүл мэндэд анхаарахгүй байх нь ГБХ-ийг даван туулагчтай ажилладаг ажилтнууд болон байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.

С. ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, АНХАН ШАТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ДУТМАГ

106. Үр нөлөөний үнэлгээний явцад зарим сум, багуудад ГБХ-тэй холбоотой асуудлуудыг мэддэггүй эсвэл үгүйсгэдэг байдал ажиглагдсан. Үнэлгээ нь тусламж үйлчилгээ үзүүлэгч болон хамтрагч талуудын үзэл бодол, ойлголтод дүн шинжилгээ хийх зорилго тавиагүй ч төрийн байгууллагын зарим төлөөлөл болон хамтарсан багийнхантай хийсэн ярилцлагаас ГБХ-ийн талаар хэвшмэл ойлголтууд байсаар байгаа нь ажиглагдлаа. Орон нутгийн зарим албан тушаалтнууд “Манай багт гэр бүлийн хүчирхийлэл байхгүй” гэж зүтгэж байсан. Үүний нэгэн адил хамтарсан багийн хэд хэдэн гишүүд ГБХ-ийн хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэгийн ач холбогдолын талаар ойлголтгүй төдийгүй зөвхөн мэргэжлийн хүн л сэтгэл засал хийж дэмжлэг үзүүлж чадна гэсэн үзэл бодолтой байсан. Гэвч сэтгэл зүйчдийн үйлчилгээ сум, багийн түвшинд байдаггүй нь бодит байдал юм.

107. Судалгааны үр дүнг үндэслэн жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, түүний гэр бүл, нийгэмд үзүүлэх үр дагавар зэрэг жендерийн мэдрэмжтэй хандлагын талаар үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг тасралтгүй бэхжүүлэхийг зөвлөж байна.

V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

A. ДҮГНЭЛТҮҮД

108. АХБ-ны Монгол Улсад КОВИД-19 халдварын тархалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх багцын нэг хэсэг болох КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх техникийн туслалцаа (MON-6530) нь Монгол Улсад КОВИД-19-ийн тархалтад нөлөөлөх жендерийн нөлөө, эмэгтэйчүүдэд үзүүлэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг бэхжүүлэхэд туслах зорилготой.

109. Энэхүү ТТ-г КОВИД-19-ийн тархалт дэгдэж эхлэх үед ГБХ-д хариу арга хэмжээ авах яаралтай тусламж болгон АХБ-аас боловсруулж, баталсан. ТТ нь ХЗДХЯ-тай хамтран хэрэгжүүлсэн туршилтын төсөл бөгөөд ГБХ-ийг даван туулагчтай ажиллах үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Ихэнх үйл ажиллагаа нь анх удаа болон туршилтын журмаар хийгдсэн. Жишээлдэл, ГБХ-н хариу арга хэмжээний хүртээмжийг сайжруулахын тулд дижитал технологийг харилцааны шинэ хэрэгсэл болгон ашигласан.

110. ТТ нь дараах гурван үр дүнг гаргахаар зорьсон. Үр дүн 1: Гэр бүлийн хүчирхийлийн эсрэг хариу арга хэмжээг дэмжиж, хамгаалах байруудын хүчин чадлыг бэхжүүлэх; Үр дүн 2: ГБХ-ээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

нэмэгдүүлэх, онлайн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох; Үр дүн 3:
Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх.

111. ТТ нь КОВИД-19 тахлын улмаас үүссэн хямралын үед авч хэрэгжүүлсэн
хөдөлгөөний хязгаарлалттай нөхцөлд яаралтай тусlamж үзүүлэх, мэдээлэл,
зөвлөгөө өгөх зэрэг яаралтай тусlamжийн үйлчилгээг хохирогчдод хүргэх,
хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой байв. ТТ нь КОВИД-19-ийн онцгой байдлын
үед яаралтай дэмжлэг шаардлагатай гурван асуудлыг тодорхойлон, түүнд
анхаарал хандуулж ажилласан

- i. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэгдсэн
тохиолдлыг нэмэгдүүлэх
- ii. Анхны хариу арга хэмжээ авах, хамгаалах байрны үйлчилгээнд аюулгүй
байдлын протокол, тоног төхөөрөмж дутмаг;
- iii. Яаралтай тусlamжийн утасны үйлчилгээний өсөн нэмэгдэж буй эрэлт
хэрэгцээнд хариу өгөх чадвар хангалтгүй.

112. **Үр нөлөөний үнэлгээ.** Төслийн үр нөлөөний үнэлгээ нь (i) хямралын үед
ажиллаж байгаа гэр бүлийн хүчирхийллийн хариу арга хэмжээ авах механизм; (ii)
урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулсан байдлыг үнэлсэн. Үр нөлөөний
үнэлгээ нь ТТ-ын хүрээнд онцгой байдлын үед авч хэрэгжүүлсэн хариу арга
хэмжээний сургамж, үр нөлөөг судалж тус улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй
тэмцэх цаашдын үйл ажиллагаанд мэдээлэл өгөх зорилгыг агуулсан.

113. **Судалгааны үр дүн. Үр дүн 1.** ТТ нь Үр дүн-1-ийн хүрээнд анхан шатны
тусlamж үзүүлэгчид, ажилтнууд, хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн аюулгүй
байдлыг нэмэгдүүлэх, шүүх эмнэлгийн тусlamж үйлчилгээний чадавхийг
сайжруулах зорилгоор зөөврийн хэт авиа оношлогооны аппарат худалдан авч
өгөхөөр төлөвлөжээ.

114. Анхан шатны тусlamж үзүүлэгчид болон хамгаалах байрны
үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор маск, бээлий,
халдвартгүйжүүлэх хэрэгсэл, (анхны тусlamжийн иж бүрдэл), гар ариутгагч, саван,
халуун хэмжигч термометр зэрэг цар тахлын үеийн ариутгал,
халдвартгүйжүүлэлтийн хамгаалах хэрэгслийг худалдан авч, улсын хэмжээний 14
түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээний төв, нийслэлийн Цагдаагийн
хэлтэст өгчээ. Хохирогчдын шүүх шинжилгээнд зориулж Зш зөөврийн хэт авиа
оношлогооны аппаратыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүлээлгэн
өгсөний нэг нь Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний лабораторид
хуваарилагджээ.

115. АХХХ-ээр хангагдсан нь үйлчилгээ үзүүлэгчид болон тэдний
үйлчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндэд зэрэгзэр нөлөөлсөн. НЦҮТ/ТХБ-ийн
нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын үеэр нийгмийн ажилтнууд маск,
нүүрний халхавчтай ажиллах нь тэдэнд дэмжлэг үзүүлж, үйлчлүүлэгч хүлээж
аваадаа аюулгүй, тайван байдлыг мэдрүүлж байсаныг хэлж байлаа. Үр нөлөөний
үнэлгээний судалгаагаар хувийн хамгааллын хэрэгсэлд хамгийн хэрэгцээтэй
зүйлс нь маск, ариутгагч, гарын саван байсан гэж судалгаанд оролцогчид
хариулжээ. Судалгаанд оролцогчид эдгээр зүйлсийг олон удаан болон удаан
хугацаанд ашиглах боломжтой байсаныг хэлж байв.

116. ТТ-ны дэмжлэгтэй зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг хүлээн
авсны дараа ШШҮХ нь орчин үеийн шинэ төхөөрөмжөөр оношилгоо хийхээс

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

гадна хорих анги гэх мэт өөр байгууллага дээр очиж оношилгоо хийх боломжтой болжээ. ШШҮХ-ийн эмч нар уг төхөөрөмжийг чанартай гэдгийг баталгаажуулсан. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шинжилгээний лабораторийн их эмч 2021 оны жилийн эцэс гэхэд гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор 515 удаагийн хэт авиан оношилгоо хийсэн бол 2022 оны 9-р сарын байдлаар оношилгоонд 640 хүн орж тэдгээрийн 78 нь буюу 12.1 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байжээ.

117. **Үр дүн-2.** ТТ-ийн Үр дүн-2-ын хүрээнд КОВИД-19 цар тахлын үед ГБХ-ийн хохирогчдын хэрэгцээг хангах зорилгоор мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ГБХ-ийн тохиолдлыг мэдээлэх тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн.
118. КОВИД-19 тахлын үед ГБХ-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх чатботуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх мультимедиа мэдээлэл сурталчилгааны кампанит ажил хожимдож эхэлсэн. Энэхүү кампанит ажил нь 2022 оны 8-р сарын сүүлч буюу чатботуудыг ажиллуулж эхэлснээс хойш нэг жил гаруйн дараа эхэлсэн. МҮОНРТ нь өөрийнх телевиз, урт долгионы радиог хэвлэл мэдээллийн кампанит ажлыг нэвтрүүлэх гол сувгаар сонгосон. Чатботуудын талаар мэдээлэл өгөх зорилготойгоор боловсруулсан телевиз, радио нэвтрүүлгүүд нь үр дүн муутай байсан. Учир нь хүмүүс нэвтрүүлгүүдийг үзээгүй ба/эсвэл агуулгыг нь ойлгоогүй байсан. Харин 2022 оны 11-р сарын сүүлээс чатботуудын талаарх мэдээллийг түгээж эхэлснээр чатбот хэрэглэгчдийн тоо нэмэгджээ. Чатботын шинэ хэрэглэгчдийн дийлэнх нь уг үйлчилгээний талаар МҮОНРТ-ын Facebook сурталчилгаанаас мэдсэн гэжээ.
119. Мультимедиа мэдээлэл сурталчилгааны кампанит ажлын хэрэгжилтэнд дараах дутагдалтай талууд ажиглагддаг. Үүнд: (а) Мультимедиа хэвлэл мэдээллийн кампанит ажил нь зорилтот бүлгийн хүн амын мэдлэгийг нэмэгдүүлэх, КОВИД 19-ийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой байсан ч энэ кампанит ажил нь КОВИД 19-ийн хязгаарлалт зогссоны дараа эхэлсэн; (б) Ажлын даалгаварын тодорхой бус байдал нь хэвлэл мэдээллийн багт хоёрдмол чиглэл өгөхөд хүргэж, улмаар чатботыг сурталчлах ажил хойшилж, гол мессеж тодорхойгүй байхад нөлөөлсэн.
120. ХЭДХЯ-ны дэргэдэх үндэсний Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн (ХЗҮХ), Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” (ХЭҮТ) төрийн бус байгууллага хоёо нь чатбот үйлчилгээ болон цахим зөвлөгөө өгөх үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор компьютер хүлээн авсан. 2021 оны 4-р сарын байдлаар ХЗҮХ болон ХЭҮТ-д хоёр чатбот ажиллуулж эхэлсэн. Хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд хүрэхийн тулд чатботуудод мессеж бичих функцийг оруулж өгсөн. ТТ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх яаралтай тусламжийн утсыг 7 хоногийн 24 цагийн турш (ердийн ажиллах цаг 08:00-17:00 цаг) тасралтгүй ажиллуулах зорилгоор ХЭҮТ-д нэг зөвлөгчийг нэмэлтээр, ХЗҮХ-д хоёр операторыг ажиллуулахад дэмжлэг үзүүлсэн.
121. ХЭҮТ-ийн мэдээлснээр чатбот ажиллаж эхэлснээс хойшх эхний гурван сарын хугацаанд 158 шинэ хэрэглэгч чатбottой холбогдож, 1109 дуудлага шинээр бүртгэгдсэн. ХЗҮХ-ийн чатбот нь 2022 оны 12-р сарын байдлаар 7410 дуудлагыг хэрэглэгчээс хүлээн авсны ихэнх нь сэтгэл зүйн зөвлөгөө авахаар холбогдсон (32.6%) байна. ХЭҮТ-ийн зөвлөгчид өдөрт дундажаар 8 хүнд, сард 240 хүнд шууд үйлчилгээ үзүүлжээ. ХЭҮТ-ийн чатбот нь хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг НЦҮТ болон хамгаалах байрны үйлчилгээ

аваагүй үед ашиглах боломжтой цорын ганц үйлчилгээ болж байна. Харин ХЗҮХ чатбот нь хүчирхийллийн хэлбэр, гэр бүл цуцлах үйл явцын талаар мэдээлэл өгдөг. ХЗҮХ-ийн опшраторууд 2022 оны 5-9 сарын хооронд 246 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгчээ.

122. Хакатоныг Монголын Масс Медиа (МММ) "Старт-Ап" ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тэмцээнд оролцохоор 72 баг бүртгүүлж, тэдгээрийн 16 нь хагас шигшээд сонгогдсон. Эцсийн шатанд хоёр баг шилдгээр тодорсон байна. Хоёрдугаар шатанд шалгарсан хоёр шийдэл нь: (а) "Тарзов" багийн боловсруулсан вэбд суурилсан цахим дээрэлхэлтийг бүртгэх мэдээллийн сантай, тухайлбал Цагдаагийн байгууллагатай бүрэн холбох боломжтой, мөн үнэл төлбөргүйгээр өөрийн үнэлгээ хийх функцтэй "Онлайн SOS" бэлгийн дарамтын талаар мэдээлэх платформ, (б) Монголын нөхцөлд зориулан #MeToo брэндийг хөгжүүлж, тоглоомын загвар ашиглан эрсдэлийн үнэлгээний онлайн хэрэглүүрийг бүтээсэн "#MeToo" баг байсан
123. Сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээр 2 удаагийн сургалтыг НЦҮТ болон ТХБ-ны ажилтнуудад зохион байгуулсан бөгөөд үүнд улсын хэмжээнд НЦҮТ/ТХБ-ны 175 ажилтан хамрагдсан. Цагдаагийн сэтгэл зүйчдэд зориулсан сэтгэцийн эрүүл мэнд, стрессийн менежментийн чиглэлээр 3 өдрийн тусдаа сургалт зохион байгуулж, улсын хэмжээнд цагдаагийн 60 сэтгэл зүйч хамрагджээ.
124. НЦҮТ/ТХБ-ны судалгаанд хамрагдагдсан ажилтнууд бүгд энэхүү сургалтыг хэрэгтэй гэж үзсэн ба 92.3 хувь нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үзсэн. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь сургалтыг цаг үеэ олсон (96.2%) гэжээ. Түүнчлэн сургалтад ороцсон НЦҮТ/ТХБ-ын ажилтнууд сургалт нь өөрийн сэтгэцийн эрүүл мэндээ нэн тэргүүнд тавих ёстойг ойлгуулсан. Судалгаанд оролцогчдын 88.5% нь сургалтыг сайн зохион байгуулсан гэж үзсэн ч цахим сургалтын хэлбэрийг оролцогчдын 60% нь л үр дүнтэй гэжээ. Сургалт ажлын цагаар зохион байгуулсан тул сургалтад хамрагдагчдын ихэнх нь ажилтай холбоотой бусад үүргээ гүйцэтгээд сургалтад анхаарлаа бүрэн төвлөрүүлж чадаагүйгээ зарим оролцогчид баталж байлаа. Үүний нэгэн адил цагдаагийн сэтгэл зүйчдийн 93% нь тус сургалтыг хэрэгтэй гэж үзсэн ч тэдний тал хувь нь өмнө нь ижил төстэй сургалтад хамрагдаж байсан гэжээ. Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь сургалт нь тэдний ажлын гүйцэтгэлд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэдэгтэй санал нийлж, 93 хувь нь сургалтыг сайтар төлөвлөсөн гэж үзсэн байна. НЦҮТ/ТХБ-ны ажилтнуудын суралцах үйл ажиллагааг дэмжих зорилгоор бэлтгэсэн гарын авлага тараагдаагүй

В. СУРГАМЖ, САЙН ТУРШЛАГА

125. Монгол Улсад КОВИД-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх техникийн туслалцаа нь Монгол Улсад КОВИД-19-ийн тархалтад нөлөөлөх жендерийн нөлөө, эмэгтэйчүүдэд үзүүлэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, бууруулах хариу арга хэмжээг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг НЦҮТ, ТХБ, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. ТТ нь эмзэг бүлгийн иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнд хэцүү нөхцөл байдлын үед үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн туршилтын үйл ажиллагааг багтаасан. ТТ нь КОВИД-19-ын хорио цээрийн дэглэмийн үед ГБХ-ийн тохиолдол нэмэгдэж байх үед авч хэрэгжүүлсэн хэрэгцээтэй бөгөөд цаг үеэ олсон хариу арга хэмжээ болжээ.

126. Онцгой байдлын үед авч хэрэгжүүлсэн техникийн туслалцаа нь мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан. Үр нөлөөний үнэлгээний явцад хэд хэдэн сургамж, сайн туршлагуудыг тодорхойлсоныг дараах хэсэгт танилцуулж байна.
127. Анхан шатны тусламж үзүүлэгчид болон хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор маск, бээлий, халдвартгүйжүүлэх хэрэгсэл, гар ариутгагч, саван, халуун хэмжигч термометр зэрэг цар тахлын үеийн ариутгал, халдвартгүйжүүлэлтийн хамгаалах хэрэгслийг цаг тухайд нь худалдан авч, тараасан нь хамгийн сайн туршлагуудын нэг нь байв. Түүнчлэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хохирогчдын шүүх шинжилгээнд зориулж З ширхэг зөөврийн хэт авиа оношлогооны аппаратыг өгсөн нь КОВИД-19-ын хөл хорионы үед ГБХ-ийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг мэдэгдэхүйц сайжруулсан.
128. Хөл хорионы дэглэмийн үеийн хөдөлгөөн хязгаарласантай холбоотой эрсдэлд өртөх, хохирогчид болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, тусламж авахад тулгарч буй хүндрэлийг бууруулах зорилгоор ГБХ-ын зөвлөгөө мэдээлэл өгөх дижитал платформыг сурталчлах, таниулах мультимедиа мэдээллийн кампанит ажил хэт хожуу эхэлсэн. ФБЯ-ийн ярилцлагууд мессежийг дамжуулахаар сонгосон сувгууд нь үр дүнтэй байсан гэж дүгнэсэн. Гэсэн хэдий ч хэвлэл мэдээллийн кампанит ажил цаг алдаж эхэлсэн тул нөлөөлөл нь бага байв. Түүнчлэн, кампанит ажлын зорилтот бүлэгт хүргэсэн мессежүүд тодорхой бус байсан. Тиймээс хэвлэл мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулахдаа илүү сайн төлөвлөлт хийх хэрэгтэй байсан бөгөөд мессежийг цацахаас өмнө урьдчилан турших шаардлагатай байсан. Хэвлэл мэдээллийн багийнхны сурталчилгааны ажлын гол зорилгын талаарх зөрүүтэй ойлголт, хүлээн авсан ойлгомжгүй чиглэлүүд нь сурталчилгааны ажил хойшлох, кампанит ажлын гол мессежүүдийг тодорхой бус болгоход нөлөөлсөн гэж үзэж байна. Хэвлэл мэдээллийн салбарын жендэрийн мэдрэмжтэй байдал, түүнчлэн ЖСХ-ийн талаарх ойлголт мэдлэг сул байгаа нь мөн ажиглагдсан.
129. КОВИД-19 тахлын үед ГБХ-ийн хохирогчдод хүрэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зөвлөгөө өгөхөд ХЭҮТ, ХЗҮХ дээр ажиллуулж эхэлсэн чатбот үйлчилгээ нь цаг үеэ олсон ажил болжээ. Түүнчлэн хөдөө орон н нутгийн иргэдэд хүртээмжтэй болго үүднээс утасны мессежийн үнэ төлбөргүй сувгийг нээсэн. Гэвч төлөвлөгөөний дагуу цар тахлын үеэр чатботуудыг сурталчилж, таниулаагүй. Энэхүү үйлчилгээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг дээр дурдсанчлан чатбот ажиллуулж эхэлснээс хойш нэг жилийн дараа л эхлүүлсэн. Үүний улмаас КОВИД 19-ийн хязгаарлалтын үед ГБХ-ийн хохирогчдод дэмжлэг үзүүлж, туслах боломж алдагдсан. “Хэрвээ хорио цээрийн дэглэмийн үед сурталчилгааг цацсан бол зарим гэр бүл салах эсвэл гэр бүл салахаас урьдчилан сэргийлэх боломжтой байсан” гэж ХБХ-ны үеэр дурдсан (аймгийн эмэгтэйчүүдийн бүлэгтэй хийсэн ФБЯ-6).
130. ХЭҮТ-ийн чатбот нь НЦҮТ болон хамгаалах байрны үйлчилгээ аваагүй байгаа боловч хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх цорын ганц эх үүсвэр болж байна. Харин ХЗҮХ чатбот нь хүчирхийллийн хэлбэр, ГБХ-ээс үүдэлтэй гэр гэр бүл цуцуулахтай холбоотой хууль эрх зүйн мэдээллээр хангахад үр дүнтэй болох нь харагдаж байна.

131. Сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн сургалтыг НҮЦТ/ТХБ-ны мэргэжлийн ажилтан, цагдаагийн сэтгэл зүйч зэрэг анхан шатны тусламж үзүүлэгчдэд зохион байгуулжээ. Сургалтад оролцогчид сургалтыг цаг үеэ олсон, хэрэгтэй, үр дүнтэй гэж үнэлсэн. Гэвч сургалтад оролцогчдын үзэж байгаагаар сургалтын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна гэсэн. Учир нь сургалтыг ажлын цагаар зохион байгуулсан тул сургалтад анхаарлаа бүрэн төвлөрүүлж чадаагүй бөгөөд зарим нь зөвхөн сургалтад ирцээ бүртгүүлэхийн тулд нэвтэрсэн гэдгээ хэлж байсан.
132. Цагдаагийн сэтгэл зүйчдэд шаардлагатай байсан сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах, стресс менежментийн сургалт анх удаа зохион байгуулагджээ. Цагдаагийн алба хаагчид сэтгэл зүйн зөвлөгөө авах нь ховор байдаг гэдгийг цагдаагийн сэтгэл зүйчид онцолж байсан. Энэ нь цагдаагийн сэтгэл зүйчид цагдаагийн алба хаагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхээс илүүтэйгээр цагдаагийн хэлтэст захиргааны ажлыг голчлон гүйцэтгэж байгаатай холбоотой байж болох юм. Ажил үүргийн ийм хуваарилалт нь сэтгэл зүйчдийг мэргэжлийнхээ хүрээнд ажиллах боломж олгохгүй байгаагаас гадна цагдаагийн ажилтнууд сэтгэл зүйчдийн үйлчилгээг ашиглах боломжийг алдахад хүргэж байна.
133. Сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежментийн чиглэлээр НҮҮТ, ТХБ-ны ажилтнуудад зориулан боловсруулсан гарын авлага тараагдаагүй. Нэг аймгийн хамгаалах байрны зөвхөн нэг ажилтан л ХЭҮТ-ээр дамжуулан гарын авлагыг хүлээн авсан. Аймгийн ГБХЗХГ-т гарын авлага өгөөгүй. НҮҮТ, ТХБ-ны ажилтнуудад давтан сургалтыг явуулж, гарын авлагыг албан ёсоор түгээх нь зүйтэй гэсэн төлөвлөгөө байсан ч төсвийн хязгаарлалтын улмаас уг үйл ажиллагааг цуцалсан байна.
134. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хямралын үед Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх ТТ нь нийгмийн эмзэг, ихэвчлэн орхигддог бүлгийг хамруулахын тулд хэд хэдэн арга хэмжээ авсан, Үүнд; (а) КОВИД-19-ын хязгаарлалтын үед хүн амын бүх бүлгийг дэмжих боломжийг олгохын тулд чатбот үйлчилгээг бий болгох замаар холбогдох сувгийн тоог нэмэгдүүлсэн, (б) Интернэт ашиглах боломж хязгаарлагдмал хөдөө орон нутагт оршин суудаг эмзэг бүлгийн хүмүүст зөвлөгөө өгөх, дэмжлэг авах боломжийг сайжруулахын тулд утасны мессежийн үйлчилгээг чатбот функцэд нэмж өгсөн; (в) ХЭҮТ нь бэлгийн өөр өөр чиг баримжаатай ЛГБТИКю бүлэгт хүрч ажиллах зорилгоор тэднийг шаардлагатай үедээ ХЭҮТ-ийн чатботтой холбогдохийг уриалсан солонгон дүрс бүхий тусгай агуулгыг нэмж өгсөн байна.

С. ЗӨВЛӨМЖҮҮД

Хэвлэл мэдээллийн кампанит ажлыг удирдан явуулахын тулд ЖСХ болон ГБХ-ийн талаар тодорхой мэдлэг, туршлагатай ТББ эсвэл байгууллагыг татан оролцуулах.

“Ковид-19 цар тахлын үед Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэх,
урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь”
Төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

Нэвтрүүлгүүдийг цацахаас өмнө зорилтот бүлгийн дунд хэвлэл мэдээллийн сурталчилгааны кампанит ажлын мессеж, сонгосон сувгуудыг урьдчилан турших.

Хэвлэл мэдээллийн багийн гол мэргэжилтэнүүдийг хэвлэл мэдээллийн кампанит ажлын мессежийг боловсруулах ажилд эхнээс нь татан оролцуулах. Үндсэн багийн гишүүдийг эхлэлийн шатнаас нь оролцуулах ёстой бөгөөд багийн бүрэлдэхүүнд гарсан аливаа өөрчлөлтийг АХБ-ны зөвлөх ажлын худалдан авалтын бодлогын дагуу үндэслэлийг гаргаж, батлуулдаг байх.

